



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

2020



**МОНГОЛ УЛСАД ЭРЧИМ ХҮЧНИЙ
ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГА ҮҮСЧ
ХӨГЖСӨНИЙ 20 ЖИЛ**

2001-2021

erc.gov.mn

АГУУЛГА

4	Мэндчилгээ
6	Эрчим хүчний зохицуулах хорооны товч танилцуулга
6	Эрчим хүчний зохицуулах хорооны зохион байгуулалтын бүтэц
7	Эрчим хүчний зохицуулах хорооны удирдлага, бүтцийн нэгжүүд
11	Эрчим хүчний зохицуулах хорооны хурал
12	Эрчим хүчний зохицуулах хорооноос 2020 онд дэвшүүлсэн зорилтуудын хүрээнд хийж гүйцэтгэсэн онцлох ажлууд
16	Эрчим хүчний зохицуулах хорооны 2020 оны төсөв, зардлын гүйцэтгэл
17	Аудитын дүгнэлт
17	Дотоод аудит
18	Тусгай зөвшөөрлийн зохицуулалт
19	Сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүр
20	Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын мониторинг, хяналт шалгалт
21	2020 онд хэрэгжүүлсэн хяналт шалгалт
23	Үнэ тарифын зохицуулалт
23	Хэрэглэгчийн үнэ, тарифын зохицуулалт
26	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тарифын зохицуулалт
29	Цахилгааны спот зах зээл
29	Нэг худалдан авагчтай зах зээл
30	Цахилгааны өрсөлдөөнт зах зээл
31	Хэрэглэгчийн цахилгаан хангамжийн найдвартай байдал
32	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн техник, эдийн засгийн үзүүлэлтүүд
34	Хэрэглэгчийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт
37	“Дулаан орчин-Хэрэглэгчийн ая тух” аян
38	Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүдийн үйл ажиллагаа
40	Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүдийг мэргэжил, аргазүйн удирдлагаар хангах чиглэлээр хийсэн ажлууд
41	Эрчим хүчний хэмнэлт, үр ашиг
48	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах чиглэлээр хийсэн ажлууд
49	Хорооны хүний нөөцийн чадавхыг сайжруулах чиглэлээр хийсэн ажлууд
50	Үйл явдлын мэдээ
52	Олон улсын хамтын ажиллагаа
54	Хорооны 2021 оны зорилтууд

Мэндчилгээ



**Эрчим хүчний зохицуулах хорооны
2020 оны тайлан сэтгүүлтэй
танилцаж байгаа эрхэм Танд энэ
өдрийн мэнд дэвшүүлье.**

Монгол Улсын Эрчим хүчний зохицуулах хорооны төдийгүй эрчим хүчний салбарын хувьд 2020 он ололт амжилтаар дүүрэн, хүндхэн сорилтыг амжилттай давж гарсан жил байлаа.

Монгол Улсын дулааны цахилгаан станцуудын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл 6.5 тэрбум кВт.ц, сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрүүдийн цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ 648.3 сая кВт.ц, дотоодын нийт үйлдвэрлэлийн хэмжээ 7.1 тэрбум кВт.ц болж өмнөх оны гүйцэтгэлээс 142.4 сая кВт.ц-аар буюу 2 хувиар нэмэгдсэн байна. ОХУ-аас худалдаж авсан импортын цахилгаан эрчим хүчний хэмжээ өмнөх оны гүйцэтгэлээс 60.1 сая кВт.ц-аар буюу 16.2 хувиар буурч 312.2 сая кВт.ц боллоо. Өнгөрсөн 2020 онд ОХУ болон БНХАУ-аас нийтдээ 1.7 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүч импортоор авсан байна. Үүний 80 хувийг буюу 1.4 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүчийг Оюутолгой ХХК нь БНХАУ-аас импортоор авчээ.

Цахилгаан эрчим хүчний хэрэглээг дотоодын үйлдвэрлэлээр хангах зорилтын хүрээнд “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн суурилагдсан хүчин чадлыг нийт 89 МВт-аар өргөтгөж, Дорноговь аймгийн Сайншанд суманд байрлалтай 30 МВт-ын хүчин чадалтай “Говь” нарны цахилгаан станц ашиглалтад орж цахилгаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгосноор нэгдсэн сүлжээний суурилагдсан хүчин чадал 119 МВт-аар нэмэгдлээ.

Эрчим хүчний зохицуулах хороо нь 2020 оны байдлаар нийт 192 хуулийн этгээдийн 11 төрлийн 317 тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг зохицуулан ажиллаж байна. Тус хорооноос 2020 онд үндсэн таван зорилт дэвшүүлэн ажиллаж, амжилттай

биелүүллээ. “Диспетчерийн үндэсний төв” ТӨХК, “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-иудад ухаалаг системийн шийдэл бүхий техник технологи нэвтрүүлэх асуудлыг 2020 оны тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын зорилтод тусгаж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа. Дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч хувийн нийт 67 аж ахуйн нэгжийн 190 гаруй ажилтан, албан хаагчдыг хамруулсан чадавхижуулах сургалтыг зохион байгуулж, хэрэглэгчийн цахим гарын авлагын мэдээллийг шинэчилж, энэ цахим системээр дамжуулан хэрэглэгчдийг эрчим хүчний хангамжтай холбоотой мэдээ, мэдээллээр хангаж байна. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд 2020 онд хэрэгжүүлсэн шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах, Эрчим хүчний тухай хуулийн дагуу ЭХЗХ-ны баталсан үнэ тарифыг мөрдөхгүй байгаа зөрчлийг арилгуулах зорилгоор нийт 3 албан тушаалтан, 7 компанид улсын байцаагчийн шаардлага хүргүүлж хэрэгжилтийг хянаж ажиллав.

Улс орны хэмжээнд коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас шалтгаалан бэлэн байдлын зэрэгт шилжсэний улмаас тулгарсан эдийн засгийн хүндрэлтэй холбоотойгоор хэрэглэгчийн үнэ тарифт өөрчлөлт ороогүй тул тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эдийн засаг, санхүүгийн хэвийн үйл ажиллагааг хангах, төвийн бүсийн “Нэг худалдан авагчтай загвар”-ын эх үүсвэргүй өр төлбөр буюу алдагдлыг бууруулах зорилгоор Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, “Диспетчерийн үндэсний төв” ТӨХК-ийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг ажиллаж тодорхой саналыг боловсруулсан.

Үүнтэй холбогдуулан ОХУ-аас худалдан авах импортын цахилгааны болон чадлын хэмжээг багасгах, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мөнгөн урсгалд нөлөөлөхгүй байдлаар худалдан авах цахилгааны өртгийг бууруулах, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдээс худалдан авах өндөр үнэтэй цахилгаан эрчим хүчний хэмжээг тарифт тусгагдсан хэмжээтэй уялдуулах, тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд тоног төхөөрөмжийн эрсдэлийг бодитой үнэлэн зарим хөрөнгө оруулалт, шинэчлэлийн ажлуудыг хойшлуулах, цуцлах, үйл ажиллагааны зардлуудыг 4-өөс доошгүй хувиар хэмнэх, зардал өсгөх чиглэлээр аливаа шийдвэрүүдийг гаргахгүй байх, цахилгаан, дулааны түгээлтийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, улмаар бизнес төлөвлөгөө, зорилтод түвшний үзүүлэлтүүдэд тодотгол хийх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлсний дүнд 2020 онд төвийн бүсийн “Нэг худалдан авагчтай зах зээлийн загвар” хуримтлагдсан дүнгээр 40.0 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллахаар байсан бол алдагдлыг 36.6 тэрбум төгрөгөөр буюу 91.3 хувиар бууруулах нөхцөлийг бүрдүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 199 дүгээр тогтоолоор баталсан “Гэр хорооллын айл өрхөд цахилгааны тарифын хөнгөлөлт үзүүлэх журам”-д өөрчлөлт оруулсны дагуу аймгийн төв, арван мянгаас дээш хүн амтай сум суурин газрын айл өрхийн орой, шөнийн хэрэглээний цахилгааны тарифыг 50 хувиар хөнгөлж байсныг 100 хувиар тооцож хөнгөлөлт үзүүлэх шийдвэрийг гаргаснаар Улаанбаатар хотод 117 мянган айл өрх, 21 аймгийн төв, Сэлэнгэ аймгийн Мандал, Өвөрхангай аймгийн Хархорин, Дорноговь аймгийн Замын-Үүд зэрэг 10 мянгаас дээш хүн амтай сум, суурин газруудад 72 мянган айл өрх, нийт 189 мянган гэр хорооллын айл өрх 100 хувийн цахилгааны тарифын хөнгөлөлтөд хамрагдах боломжтой болсон. Нийслэл болон аймгуудын төв, 10,000-аас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын айл өрхийн орой, шөнийн цахилгааны хэрэглээний тарифын хөнгөлөлтөөс үүсэх 18.1 тэрбум төгрөгийн санхүүгийн дутагдлыг Улсын төсвийн санхүүжилтээр шийдвэрлүүлсэн юм.

Монгол Улсын Засгийн газрын “Өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 324 дүгээр тогтоолын дагуу цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон, цагийн ялгаварт тарифт тоолууртай өвлийн хүлэмжийн аж ахуйн шөнийн цагт хэрэглэсэн /шөнийн 22.00 цагаас өглөөний 6.00 цаг хүртэл/ цахилгааны тариф болон дэмжих тарифыг жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд 100 хувиар хөнгөлөлт үзүүлэх шийдвэрийг гарган 2019, 2020 онд шаардлагатай санхүүжилтийн тооцоо судалгааг хийж, улсын төсөвт тусгуулах асуудлыг хариуцан ажилласан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор айл өрхийн болон зарим аж ахуйн нэгж, байгууллагын хэрэглэсэн цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын төлбөрийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөх шийдвэр гарсантай холбоотойгоор холбогдох тооцоо, судалгаа, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлох, Эрчим хүчний зохицуулах хороо болон аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүдийн нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төлбөр тооцооны урьдчилгаа болон гүйцэтгэлийн мэдээллийг нэгтгэн хянах арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Засгийн газрын энэ тогтоолын дагуу 2020 оны 12 дугаар сард хэрэглэгчийн цахилгаан дулааны төлбөр болох 53.7 тэрбум төгрөгийг төрөөс хариуцсан байна.

Эрчим хүчний сайдын 2020 оны 206 дугаар тушаалаар байгуулагдсан Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хорооны хамтарсан ажлын хэсэг төвлөрсөн дулаан хангамжтай аймгийн төв, сум, суурин газарт үйл ажиллагаа явуулж байгаа 15 аймгийн төрийн өмчит 6, орон нутгийн өмчит 7, хувийн өмчит 6, нийт 19 үйлдвэр, компанид ажиллан техник, санхүү эдийн засгийн өнөөгийн байдал, тулгамдаж буй хүндрэлтэй асуудлууд, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар газар дээр нь ажиллаж Эрчим хүчний сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх талаар хурлын тэмдэглэл гаргаж хэрэгжүүлж эхлээд байгаа бөгөөд Монгол Улсын Засгийн газарт танилцуулахаар болсон юм.

Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд Эрчим хүч хэмнэлтийн менежер, аудиторын шинэчилсэн сургалтын хөтөлбөрт Эрчим хүчний удирдлагын тогтолцооны ISO стандартын талаарх хичээлийг тусган зааж байна. Эрчим хүч хэмнэх Үүрэг хүлээсэн 129 хэрэглэгчийн 2019 оны үйл ажиллагааг Хорооны 2019 оны 419 дүгээр тогтоолоор баталсан аргачлалын дагуу үнэлэн Хорооны хурлаар хэлэлцэн дүгнэв.

Эрчим хүчний зохицуулах хороо нь хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалах зорилгын хүрээнд 2020 онд нийтдээ 1590 хэрэглэгчийг хамарсан гомдлыг хүлээн авч, 600 гаруй сая төгрөгийн маргаантай асуудлыг хуулийн дагуу хянаж, шийдвэрлэсэн байна.

2021 онд Монгол Улсад эрчим хүчний зохицуулах байгууллага үүсч хөгжсөний 20 жилийн ой тохиож байна. Манай хорооны хамт олон өнгөрсөн 20 жилд хийж бүтээсэн ажлаа үнэлж цэгнэн, ирэх жилүүдэд хийж бүтээх зүйлээ төлөвлөн ажиллаж байна.


Та бүхэн манай 2020 оны үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлантай танилцаж, бидэнд үнэтэй зөвлөгөө өгнө гэдэгт итгэлтэй байна.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА



Алмаликийн ТЛЕЙХАН

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА




ЧИГ ҮҮРЭГ

Эрчим хүчний тухай хуулийн дагуу эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлэхийн хамт Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн дагуу эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

ҮНДСЭН ЗОРИЛГО

Эрчим хүчний хангамжийн найдвартай ажиллагаа, салбарын санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, үр ашгийг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих, эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх болон хангагч, хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалахад чиглэсэн зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн тогтолцоог бүрдүүлнэ.

ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ



УДИРДЛАГА




ЭХЗХ-ны дарга А.Тлейхан, Зохицуулагч Э.Түвшинчулуун, Б.Баттулга, УМягмарсүрэн, Э.Самдан

Эрчим хүчний тухай хуулийн дагуу Эрчим хүчний зохицуулах хороог орон тооны гурав, орон тооны бус хоёр, нийт таван гишүүний бүрэлдэхүүнтэй зохицуулагчид удирддаг. Зохицуулах хорооны дарга, орон тооны хоёр зохицуулагчийг эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал, орон тооны бус хоёр зохицуулагчийг Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Хэрэглэгчийн

эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн саналыг тус тус үндэслэн Ерөнхий сайд томилдог болно. Эрчим хүчний зохицуулах хорооны даргаар А.Тлейхан, орон тооны зохицуулагчаар Э.Түвшинчулуун, Б.Баттулга, орон тооны бус зохицуулагчаар УМягмарсүрэн, Э.Самдан нар томилогдон ажиллаж байна.

АЖЛЫН АЛБА



Ажлын алба нь Эрчим хүчний зохицуулах хорооны дүрмийн дагуу түүний өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, гарсан шийдвэр, үүрэг, даалгаврын биелэлтийг зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй бөгөөд Хорооны дарга, гишүүдийг холбогдох мэдээ, баримт, судалгаагаар хангах, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, үнэ тариф,

хэмнэлтийн бодлогын талаар санал боловсруулах, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн санхүү, эдийн засгийн байдал, зардалд болон эрчим хүч хэмнэх арга хэмжээний биелэлтэд дүн шинжилгээ хийх, Хорооны эрх хэмжээнд хамаарах асуудлаар хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын төсөл боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аппаратын удирдлага юм.

ДОТООД АУДИТЫН ГАЗАР



Дотоод аудитын газар нь Эрчим хүчний зохицуулах хорооны эрсдэлийн удирдлага, хяналтын үйл ажиллагааны үр дүнг хараат бусаар үнэлж дүгнэн, зөвлөмж өгөх замаар Хорооны үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллаж байна. Үүнд:

- Хорооны болон аймаг, Нийслэлийн зохицуулах зөвлөлүүдийн үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын дагуу явагдаж байгаа эсэх;
- Хорооны тогтоолын хэрэгжилт;
- Хорооны зохицуулагчдаас Ажлын алба, түүний нэгжүүд удирдлагад өгсөн үүрэг, даалгаврын биелэлт;

- Дээд болон холбогдох бусад байгууллагаас Хороонд өгсөн үүрэг, даалгаврын биелэлт;
- Хорооны жилийн болон сарын ажлын төлөвлөгөөний биелэлт;
- Хөндлөнгийн аудитын зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;
- Хорооны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаа;
- Ажлын албаны чиг үүргийн хэрэгжилт;
- Хорооны жилийн үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэл;
- Эрсдэлийн үнэлгээ;
- Төлөвлөгөөт бус тусгайлан явуулах бусад аудит;


ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ХЯНАЛТЫН ГАЗАР



Тусгай зөвшөөрлийн болон хяналт шалгалтын талаар баримтлах бодлого чиглэлийг боловсруулах, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хянах, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн санхүү, техник-эдийн засгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, тэдгээрийн техник, эдийн

засгийн үзүүлэлтүүд, эрчим хүчний хэрэглээний талаар мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигчид хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэх, холбогдох дүрэм, журмуудыг боловсронгуй болгох чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ХЭРЭГЛЭГЧ, ОРОН НУТГИЙН ХЭЛТЭС



Хорооны бүрэн эрхэд хамаарах асуудлаар тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч хоорондын гомдол, маргааныг шийдвэрлэх, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах; аймаг, нийслэлийн эрчим хүчний зохицуулах

зөвлөлүүдийн гишүүдийг томилох, чөлөөлөх ажлыг зохион байгуулах; зохицуулах зөвлөлүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих, ажлын заавар, удирдамжаар хангах, үнэлэлт дүгнэлт өгч сургалт, зөвлөгөөн зохион байгуулан ажиллаж байна.

ҮНЭ ТАРИФ, ЗАХ ЗЭЭЛИЙН ГАЗАР



Эрчим хүчний үнэ тариф, зах зээлийн загвар, тогтолцооны талаар баримтлах бодлого, чиглэлээр санал боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тусгай зөвшөөрлийн төрөл тус бүрээр тарифын бүтцийг тодорхойлох, хэрэглэгчдэд худалдах үнийг тооцох, тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс ирүүлсэн тарифын саналыг хянах, тэдгээрийн

тооцож гаргасан өртөг, зардлын үндэслэл, үнэн зөв байдалд үнэлгээ өгөх, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн санхүү, эдийн засгийн байдал, үйл ажиллагааны зардалд дүн шинжилгээ хийх, цахилгаан, дулааны эрчим хүчний үнийн өсөлтийг макро эдийн засгийн түвшинд шинжилж судлах, дүгнэлт гаргах зэрэг чиглэлээр ажиллаж байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС



Эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, хангах үйл ажиллагаанд зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийг олон улсын түвшинд судалж нэвтрүүлэх, эрчим хүчний хэрэглээг хамгийн бага өртгөөр хангах чадавхыг бүрдүүлсэн, ашгийн зохих түвшинг хангасан, үнэ тарифын тогтолцоог бий болгох нөхцөлийг

бүрдүүлэх, салбарын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалтыг татах, хамтын ажиллагааг хөгжүүлэх болон цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээтэй холбоотой зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байна.

ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ГАЗАР



Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд заасан Хорооны чиг үүргийн дагуу эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулж Засгийн газарт тайлагнах, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах болон Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлж бүртгэх, эрчим хүч хэмнэх үйл ажиллагаанд мэргэжил арга

зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллах, эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх, мэргэшүүлэх, эрчим хүчний аудит болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх байгууллагыг магадлан итгэмжлэх, мэдээлэл, сурталчилгааны системийг хөгжүүлэх, эрчим хүчийг хэмнэх замаар хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх зэргээр дэвшилтэт техник, технологид суурилсан эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАР




Эрчим хүчний зохицуулах хорооны хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхжуулах, мэргэшүүлэх, архив, албан хэрэг хөтлөлт, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх, Хорооноос гаргаж буй шийдвэрүүдийн хууль зүйн үндэслэлийг хангуулах, салбарын болон зохицуулалтын үйл ажиллагааг

сурталчлах, хэвлэл, олон нийттэй харилцах, хэрэглэгчдэд эрчим хүчний боловсрол, мэдлэг олгох, мэдээллээр хангах; цахим мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагааг хангах, боловсронгуй болгох, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг шуурхай явуулах нөхцөлийг бүрдүүлэх үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна.

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛҮҮД

Улаанбаатар хот болон 21 аймагт эрчим хүчний хангамжийн төрийн зохицуулалтыг аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүд хэрэгжүүлдэг. Зохицуулах зөвлөлүүд нь Эрчим хүчний зохицуулах хорооноос томилсон 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж эрчим хүчний тусгай

зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг хянах, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тариф, хэрэглэгчдийн үнийг батлах, эрх ашгийг хамгаалах, холбогдох дүрэм журмыг хэрэгжүүлэх хяналт тавих зэрэг эрх, үүрэгтэй ажиллаж байна.




ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХУРАЛ

Эрчим хүчний зохицуулах хороо нь 2020 онд урьдчилсан хэлэлцүүлгийг 39 удаа зохион байгуулж 433 асуудал авч хэлэлцсэн байна. Мөн хорооны хурлыг 36 удаа хийж тусгай зөвшөөрөл шинээр олгох, хугацааг сунгах, хэрэглэгчдийн болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үнэ тарифыг хянаж батлах, тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон

хэрэглэгчид дагаж мөрдөх дүрэм, журмуудыг батлах, үүрэг даалгавар өгөх, Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүдийн дарга, гишүүдийг томилох, чөлөөлөх болон Хорооны дотоод үйл ажиллагаатай холбоотой нийт 475 асуудлыг хэлэлцэн 652 тогтоол батлан гаргасан байна.

График 1


Хурлаар хэлэлцсэн асуудлыг хариуцсан нэгж тус бүрээр нь авч үзвэл:



Хуралд оруулсан асуудлын тоо

График 2

Хурлаас гарсан шийдвэр буюу тогтоолыг төрлөөр нь авч үзвэл:



Тогтоолын тоо



Дэлхий дахинд тархаад буй Covid-19 коронавирусийн халдвараас сэргийлэх зорилгоор Эрчим хүчний зохицуулах хорооны хурлыг цахимаар зохион байгуулж байна.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС 2020 ОНД ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛТУУДЫН ХҮРЭЭНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ОНЦЛОХ АЖЛУУД

Нэг. Эрчим хүчний ухаалаг сүлжээ, мэдээллийн технологийг хөгжүүлэх, хэрэглэгчдийг найдвартай, чанартай эрчим хүчээр хангах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах;

- “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК, “Дулааны 4 дүгээр цахилгаан станц” ТӨХК, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-иудад ухаалаг системийн шийдэл бүхий техник технологи нэвтрүүлэх асуудлыг 2020 оны тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын зорилтод тусгаж хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа.
- Иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч, хариу өгөх, шийдвэрлэлтийг хянах, иргэдээ сонсох, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг цаасгүй, түргэн шуурхай, хүнд сурталгүй хүргэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 11-11 төвийн цахим системд Хорооны Хэрэглэгч, орон нутгийн хэлтсийн ажилтнууд нэвтэрч эрчим хүчний хэрэглэгч, олон нийтэд холбогдох мэдээлэл, зөвлөмжийг өгч, хэрэглэгчийн хууль ёсны эрх ашиг хөндөгдсөн өргөдөл, гомдлуудыг шийдвэрлэн хариуг өгч, холбогдох арга хэмжээг тухай бүрд нь авч ажиллаж байна.
- Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор зохион байгуулсан “Дулаан орчин-Хэрэглэгчийн ая тух” сэдэвт 2 сарын аяны хүрээнд Эрчим хүчний тухай хууль, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм, Хангагч, хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрмүүдийг сурталчлан ажиллав.
- Хэрэглэгчийн цахим гарын авлагын мэдээллийг шинэчилж, энэ цахим системээр дамжуулан хэрэглэгчдийг эрчим хүчний хангамжтай холбоотой мэдээ, мэдээллээр хангаж ажилласан.
- Дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч хувийн хэвшлийн 66 компани, орон нутгийн өмчит 1 газар, нийт 67 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 190 гаруй ажилтан, албан хаагчдыг хамруулсан хоёр өдрийн чадваржуулах сургалтыг зохион байгууллаа.

Хоёр. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтэд тавих хяналт, чанар, үр нөлөөг дээшлүүлэх, эрсдэлд суурилсан мониторинг хийх;

- Цахилгаан дамжуулалт, түгээлтийн алдагдлын норм, норматив, дулааны цахилгаан станцуудын дотоод хэрэгцээний цахилгаан, жишмэл түлшний хувийн зарцуулалтын норм, нормативыг тогтоох аргачлалын төслийг боловсруулж цахилгаан дамжуулах, түгээх компаниудын техникийн алдагдлын нормыг тодорхойлох ажлыг Эрчим хүчний яам, Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн, Монголын эрчим хүчний инженерийн холбоотой хамтран хэрэгжүүлж эхлээд байна.
- Дэлхийн банкнаас зохион байгуулсан “Эрсдэлд суурилсан мониторинг хийх” сургалтад холбогдох мэргэжилтнүүд оролцож, практик дадал эзэмшин тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын 2020 оны зорилтыг тогтоохдоо компани тус бүрийн тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны эрсдэлт нөхцөл байдлыг харгалзан үзсэн.
- Хорооноос Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай Хамтран ажиллах гэрээг 2019 онд байгуулан ажиллаж байна. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын тушаалаар Хорооны 2 ажилтан, “Дулааны 2 дугаар цахилгаан станц”, “Дулааны 3 дугаар цахилгаан станц”, “Дулааны 4 дүгээр цахилгаан станц”, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ”, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ”, “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-иудын холбогдох техникийн хяналтын нэгжийн дарга, инженер зэрэг 6 албан тушаалтанд Эрчим хүчний зохицуулах хорооны нэр дээр Эрчим хүчний хяналтын

улсын байцаагчийн эрх олгосон. Эдгээр 8 албан тушаалтанд Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын холбогдох дүрэм, журам, аргачлалын хүрээнд мэргэжлийн хяналтын байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал, хяналтын хуудсыг ашиглан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн.

- “ББЭХС” ТӨХК, “АУЭХС” ТӨХК болон тэдгээрийн охин компаниудад хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг газар дээр нь шалгаж мөн тус

компаниудын инженер техникийн ажилтнуудад зориулсан сургалтыг “УБЦТС” ТӨХК-тай хамтран 2020 оны 09 дүгээр сард зохион байгууллаа.

- Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд 2020 онд хэрэгжүүлсэн шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах, Эрчим хүчний тухай хууль зөрчиж ЭХЗХ-ны баталсан үнэ тарифыг мөрдөхгүй байгаа зөрчлийг арилгуулах зорилгоор нийт 3 албан тушаалтан, 7 компанид улсын байцаагчийн шаардлага хүргүүлж хэрэгжилтийг хянаж ажиллав.

Гурав. Эрчим хүчний үнэ тарифын тогтолцоог сайжруулах, зах зээлийн оновчтой загварыг нэвтрүүлэх боломжийг тодорхойлох;

- Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн зардлыг бууруулах, эрчим хүч хэмнэх, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх хөшүүрэг, сонирхлыг бий болгох зорилгоор тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулж, түүний үр дүнгээр урамшуулж идэвхжүүлэхэд чиглэсэн “Урамшуулалт зохицуулалтын журам”-ын дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудтай “Урамшуулалт зохицуулалтын гэрээ” байгуулан ажилласан билээ. Тус гэрээг дүгнэсний дагуу 3,706.7 сая төгрөгийн урамшууллыг тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудад олгохоор шийдвэрлэж борлуулалтын орлогын шаардагдах хэмжээнд тусгасан.

Эрчим хүчний зохицуулалтын үр ашгийг хэрэглэгчийн тарифт тусгах боломжийг бүрдүүлэх зорилгын хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудад дотоод хэрэгцээ, жишмэлтүлшний хувийн зарцуулалт, дамжуулалт, түгээлтийн алдагдал, зардлын хэмнэлтээс бий болсон үр ашгийг хэрэглэгчтэй 50:50 харьцаагаар хуваарилах саналыг боловсруулж ЭХЗХ-ны урьдчилсан хурлаар хэлэлцээд байна.

- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн тогтоолоор “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 114 дүгээр тогтоолоор цахилгаан эрчим хүч хэрэглэгч айл өрхүүдийн хэрэглээний төлбөрт алданги оногдуулахгүй байх, төлбөрөө төлөөгүй өрхүүдийн цахилгааныг хязгаарлах арга хэмжээ авахгүй байх талаар

үүрэг болгосон. Мөн коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд заасан “Цар тахлын үед өргөн хэрэглээний болон стратегийн ач холбогдол бүхий зарим бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байхад чиглэсэн төрийн зохицуулалтын арга хэмжээг авах”, Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан “Бүтээгдэхүүний үнийн хөөрөгдөл үүсэхээс сэргийлэх, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ авах” үүргийн дагуу Зохицуулах хороонд эрчим хүчний үнэ тарифт өөрчлөлт оруулах боломж бүрдээгүй юм.

Эрчим хүчний салбар хөрөнгийн эх үүсвэрийн дутагдалтайгаас, мөн гадаад хүчин зүйлүүдийн нөлөөллөөс шалтгаалан 2020 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нэг худалдан авагчтай загвар (НХАЗ) 28.5 тэрбум төгрөгийн, хуримтлагдсан дүнгээр 40.0 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллах урьдчилсан тооцоо гарсан. Мөн НХАЗ-т алдагдал үүсэж байгаатай холбоотойгоор НХАЗ-ын авлага 69.6 тэрбум төгрөг, НХАЗ-ын өглөг 111.4 тэрбум төгрөг болохоор байсан.

Эрчим хүчний салбарын санхүү эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулах, НХАЗ-ын алдагдал, эх үүсвэргүй өр төлбөрийг бууруулах зорилгоор ОХУ-аас худалдаж авах импортын ЦЭХ болон чадлын хэмжээг бууруулах, СЭХ-ний эх үүсгүүрүүдээс худалдаж авах ЦЭХ-ний хэмжээг тарифт тусгагдсан хэмжээтэй уялдуулах, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мөнгөн урсгалын хэмжээнд нөлөөлөхгүйгээр тарифт өөрчлөлт оруулах, цахилгаан түгээх, хангах ТЗЭ-дийн

авлагыг бууруулах, тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн холбогдох үзүүлэлтүүдийг тодотгохдоо үйл ажиллагааны зардлыг 2 хувиас доошгүй хэмжээгээр бууруулах, хөрөнгө оруулалт, ТЗБАХ-гээр хэрэгжүүлэх ажлуудыг хөрөнгийн эх үүсвэртэй уялдуулан эрэмбэлэх байдлаар гүйцэтгэх, авлага, өглөгийг бууруулах хугацаатай аян зохион байгуулах зэрэг арга хэмжээнүүдийг авсан. Үүний үр дүнд НХАЗ-т үүсэхээр байсан 40.0 тэрбум төгрөгийн алдагдлыг бууруулж 3.5 тэрбум төгрөг болгосон.

- Нэгдсэн сүлжээний хүрээнд НХАЗ-ын цахилгаан үйлдвэрлэх ТЗЭ-дийн хооронд цахилгаан үйлдвэрлэлийн ачааллыг нэмж, орлого нэмэгдүүлэн өрсөлдөөн бий болгох, үйлдвэрлэгчдийн хослон үйлдвэрлэлийг нэмэгдүүлж нэгжийн өртгийг хямдруулах, диспетчерийн зохицуулалтын тухайн агшинд системийн нийт хувьсах зардлыг хамгийн бага хэмжээнд хүргэн системийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор “Цахилгааны өрсөлдөөнт зах зээлийн дүрэм”-ийг мөрдөж ажилласан.
- Эрчим хүчний сайдын 2018 оны 201 дүгээр тушаалаар эрчим хүчний салбарын аж ахуйн нэгж, компаниудын бүтэц, зохион байгуулалт, орон тооны хязгаарыг оновчтой тогтоох аргачлалыг боловсруулж, танилцуулахыг Төрийн захиргаа, удирдлагын газар, Эрчим хүчний зохицуулах хороонд тус тус даалгасны дагуу тус Хорооны даргын 2019 оны А/03 дугаар тушаалаар Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн, “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК, “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК, “Диспетчерийн үндэсний төв” ТӨХК, Эрчим хүчний инженерүүдийн холбооны төлөөлөл болон ахмад ажилтнууд зэрэг 19 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан ажлын хэсэг нь аж ахуйн нэгж, байгууллагын орон тооны норм, нормативын талаар хууль эрхзүйн зохицуулалт, тэдгээрийн хэрэгжилтийн талаар судлах, ОХУ болон Казахстан улсын эрчим хүчний үйлдвэрт ашиглаж буй нормативын талаар нийт 350 хуудас бүхий үндсэн 3 баримт бичгийг орчуулан судлах, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэргэжилтнүүдтэй хамтарч дээрх нормативын дагуу ажиллагсдын тоог тооцож, бодит гүйцэтгэлтэй харьцуулан, холбогдох дүгнэлт, саналыг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.
- Эрчим хүчний салбарын бүтцийг оновчтой болгох санал боловсруулахтай холбоотойгоор

гадаад улс орнуудад хэрэгжиж буй бүтцийн нийтлэг загварууд, хөрш зэргэлдээ орших ОХУ, БНХАУ, мөн зах зээл өндөр хөгжсөн боловч төрийн өмч давамгайлсан БНСУ, түүнчлэн Австрали улсын бага хүчин чадал, жижиг систем бүхий Баруун Австрали мужийн эрчим хүчний салбарын бүтцүүдийг судалж холбогдох дүгнэлтийг гаргасан.

- Эрчим хүчний сайдын 2020 оны 206 дугаар тушаалаар байгуулагдсан Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хорооны хамтарсан ажлын хэсэг төвлөрсөн дулаан хангамжтай аймгийн төв, сум, суурин газарт үйл ажиллагаа явуулж байгаа 15 аймгийн төрийн өмчит 6, орон нутгийн өмчит 7, хувийн өмчит 6, нийт 19 үйлдвэр, компанид ажиллан техник, санхүү эдийн засгийн өнөөгийн байдал, тулгамдаж буй хүндрэлтэй асуудлууд, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар газар дээр нь ажиллаж Эрчим хүчний сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.

Аймгийн төвүүдийн дулааны станц болон дулаан дамжуулах, түгээх шугам сүлжээ хүчин чадлын дутагдалд орж өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах боломжгүй болсон, дулаан дамжуулах, түгээх шугам сүлжээ хуучирч элэгдсэнтэй холбоотойгоор үйл ажиллагаа нь доголдож байгаа зэрэг хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх талаар хурлын тэмдэглэл гаргаж, улмаар Монгол Улсын Засгийн газарт танилцуулахаар болсон. Мөн Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацааны дараа эхний ээлжид ахуйн хэрэглэгчийн 1 м² дулааны тарифыг 2021 онд 600 төгрөгт, 2022 онд 800 төгрөгт хүргэж бүх аймгийн ахуйн хэрэглэгчийн дулааны тарифыг ижил болгох шаардлагатай байгаа юм.

- Айл өрхийн болон зарим аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс тооцож 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөх арга хэмжээг авах болсонтой холбогдуулан тооцоо, судалгаа, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлох зэрэг арга хэмжээг авч ажилласан. Үүнтэй холбоотойгоор “Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах түр журам”, “Цахилгаан,

дулааны эрчим хүч, дулааны уурын төлбөр тооцоог зохицуулах түр журам"-ыг боловсруулах, цахилгаан, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд танилцуулах, зөвлөмж, чиглэл өгөх ажлуудад оролцож ажилласан. Мөн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 199 дүгээр тогтоолоор батлагдсан "Гэр хорооллын айл өрхөд цахилгааны тарифын хөнгөлөлт үзүүлэх журам"-ын дагуу Эрчим хүчний зохицуулах хорооноос агаарын бохирдлыг бууруулах зорилгоор нийслэл хот болон аймгийн төв, арван мянгаас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын хоёр тарифт тоолууртай

айл өрхийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифт хөнгөлөлт үзүүлж э хэлсэнтэй холбогдуулан зөрчил дутагдлыг арилгах зорилгоор цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд хяналт шалгалт хийж холбогдох зөвлөмжийг гаргасан.

- Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6.5-д заасан "Хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс үйлдвэрлэсэн цахилгааныг түгээх сүлжээнд нийлүүлэх үнэ, тарифыг жил бүр хянаж тогтоох" гэсэн хуулийн заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор хэрэглэгчдийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс цахилгаан эрчим хүч нийлүүлэх загварыг боловсруулсан.

Дөрөв. Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр (2018-2022 он)-ийн хэрэгжилтийг хангах, дэвшилтэт техник, технологид суурилсан, эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг санаачлах, хэрэгжилтийг зохион байгуулах;

- Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийн 4.8, 4.13 дахь зорилт, үйл ажиллагааг хангах зорилгоор "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, бусад төсөвт байгууллагуудыг тоолууржуулах тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 144 дүгээр тогтоолыг батлуулж ажиллав. Мөн Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж Төрийн худалдан авах ажиллагааны газартай хамтран дулааны тоолуурын худалдан авах ерөнхий гэрээний тендер шалгаруулалтыг зохион байгуулав. Орон нутгийн удирдах байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нарыг мэдээллээр хангав.
- Барилгын эрчим хүчний хэрэглээ, гүйцэтгэлийг тодорхойлох БНБД 25-01-20 Барилгын дулаан хамгаалалт нормыг боловсруулах, хэлэлцүүлэх ажилд оролцож, Барилга хот байгуулалтын сайдын 2020 оны 146-р тушаалаар батлагдав. Мөн барилгын эрчим хүчний аудитуудад шинэ нормыг танилцуулах сургалт явуулав.
- Хэрэглэгчийн дулааны эрчим хүчний төлбөрийг хэрэглээнд суурилсан зарчимд шилжүүлэхэд суурь болох халаалтын зардлыг хуваарилах Аллокаторын MNS EN 834:2020 стандартыг үндэсний стандарт болгон батлуулав.
- Мөн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахаар Олон улсын цахилгаан техникийн хорооноос гаргасан барилгын эрчим хүчний гүйцэтгэлийг тооцохтой холбоотой, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, хөргөгч, цахилгаан зуух, угаалгын машины эрчим хүчний гүйцэтгэлийг тооцох стандартуудыг орчуулж, батлуулах бэлтгэлийг хангав.
- Эрчим хүчний хэмнэлтийн үндэсний хэмжээний тайлан боловсруулах болон хүлэмжийн хийн ялгарлыг тооцох, батлах, тайлагнах үндэсний системийг бүрдүүлэх судалгаа, нэгж бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний эрчим хүчний зарцуулалтыг нормчлох суурь судалгааны ажлуудыг Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгээр эхлүүлэв.
- Эрчим хүчний менежментийн тогтолцооны стандартыг нутагшуулах, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулав. Германы Физик техникийн хүрээлэн, Стандарт хэмжил зүйн газар, "Эрчим хүчний чанарын дэд бүтцийг сайжруулах" төсөлтэй хамтран "ISO 50001" Стандартыг нэвтрүүлэх мэргэжилтнүүд, сургагч багш нарыг бэлтгэх сургалтыг зохион байгуулав.
- Нийслэлийн Засаг даргын А/27 тоот захирамжаар батлагдсан "Хотын соёл" мэдээллийн цаг арга хэмжээний 1-4 дүгээр ангийн "Хэрэглээний соёл" агуулгад эрчим

хүчний хэмнэлт, хэрэглээний талаарх сэдвийг тусгаж сурагчдад эрчим хүчийг зохистой хэрэглэх, хэмнэх тухай таниулах, дадал эзэмшүүлэх мэдээллийг түгээх ажлыг хийж байна.

- Эрчим хүчний хэрэглээний шошгын ач холбогдлыг таниулах, сурталчлах аяны хүрээнд цахилгаан бараа импортлох, худалдаалах үйл

ажиллагаа эрхлэгч байгууллагуудад “Эрчим хүчний хэрэглээний шошго түүний ач холбогдол” сэдэвт уулзалт семинар зохион байгуулан, цаашид эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан бараа, тоног төхөөрөмж худалдах, хэрэглэгчдэд танилцуулах, хамтран ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж эхлээд байна.

Тав. Хорооны үйл ажиллагааны удирдлага, гүйцэтгэлийн менежментийг хөгжүүлэх, байгууллага, хамт олны соёлыг төлөвшүүлэх, ажилтнуудын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх, өндөр хөгжилтэй улс оронд суралцах боломжийг бүрдүүлэх;

- Хорооны Хөгжлийн стратегийн баримт бичиг, төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, удирдлагын болон гүйцэтгэлийн менежментийг хөгжүүлэх зорилгоор Монголын бүтээмжийн төвтэй хамтран Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагчид, газар, хэлтсийн дарга нарт зориулсан Тэнцвэржүүлсэн үнэлгээний картын системийн талаарх сургалт-семинарыг зохион байгуулсан.
- Хорооны нийт ажилтнуудад байгууллагын соёл, хувь хүний харилцаа, хандлагыг сайжруулах зорилгоор Байгууллагын соёлыг хөгжүүлэх нь, Байгууллагын зан төлөв, Эерэг хандлага, Харилцааны соёл, ёс зүй, Ажилтны дүр төрх бүрдүүлэлт, Цагийн менежмент ба хувийн зохион байгуулалт, Угтах, үдэх ба халамжлах үйлчилгээ зэрэг сэдвүүдээр нийт 10 цагийн сургалт, мөн “Байгууллага, хамт олны соёл-Зөв хандлага, харилцааны соёл” сэдэвт илтгэх ур чадварын тэмцээнийг 05 дугаар сард зохион байгууллаа.
- 2019 онд зохион байгуулсан Англи хэлний анхан шатны сургалтыг амжилттай төгссөн нийт 11 ажилтныг хамруулан Англи хэлний дунд шатны танхимын сургалтыг “Сантис” боловсролын төвтэй хамтран 4 сарын хугацаанд зохион байгуулав.
- ХБНГУ-ын ВЕУТН Техникийн Их Сургуулийн Сэргээгдэх эрчим хүчний магистрын зайн сургалтад 1 мэргэжилтэн, БНСУ-ын АЖОУ-гийн Их сургуульд КОИКА-АЖОУ-гийн тэтгэлгээр Хорооны 2 мэргэжилтэн, Австрали улсын Куинсландын Их сургуулийн Эрчим хүчний менежментийн магистрын сургалтад 1 мэргэжилтэн Австралийн Засгийн газрын тэтгэлгээр суралцах нөхцөлийг хангаж, сургалтад хамруулж байна.
- Урамшуулалт зохицуулалт, эрсдэлд суурилсан мониторингийн сургалтыг холбогдох ажилтнуудад зориулж Дэлхийн банкны экспертүүдтэй хамтран цахимаар зохион байгуулсан болно.

2020 ОНЫ ТӨСӨВ, ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.18, 9.1.20 дахь заалтуудыг үндэслэн Хорооны 2020 оны үйл ажиллагааны зардлын хэмжээг Эрчим хүчний зохицуулах хорооны 2020 оны 16 дугаар тогтоолоор 4,821.8 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын хэмжээг 17 дугаар тогтоолоор 556.8 сая төгрөгөөр тус тус батлан, санхүүгийн үйл ажиллагааг явууллаа. 2020 оны санхүүгийн тайлангаар үйл ажиллагааны зардал 4,352.3 сая төгрөг буюу 9.7 хувийн хэмнэлттэй, хөрөнгө оруулалтын зардалд 556.9 сая төгрөг төсөвлөснөөс

386.7 сая төгрөгийн худалдан авалт хийж 69.4 хувийн гүйцэтгэлтэй гарсан. Үйл ажиллагааны зардлын 75.8 хувийг Хорооны ажилтан, албан хаагчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, 5.6 хувийг аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүдийн зардал, 4.5 хувийг албан томилолт, сургалт, мэргэжлийн үйлчилгээ, хэвлэл, мэдээллийн зардал, 6.6 хувийг бичиг хэрэг, хангамжийн материал, шатахуун, харилцаа холбоо, ашиглалт, засвар үйлчилгээний зардал, 1.1 хувийг албан татвар, хураамж, даатгалын зардал тус тус эзэлж байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА А.ТӨГӨХ**

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
10160 Улаанбаатар хот, Нийслэл 16 дугаар
Бага тогтоо 3, Засгийн газрын IV байр
Утас: 26 04 37, Факс: 51 26 12 30
E-mail: info@audit.gov.mn

2021.03.15 № 07/871
Танай -ны № -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчим хүчний зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцэтгэлийн тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, материаллаг алдаагүй, Нийтлэн бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Эрчим хүчний зохицуулах хороо тайлант онд 5 зорилтын хүрээнд 35 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 82.1 хувийн гүйцэтгэлтэй гэж зохицуулагчдын зөвлөл дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

001051815

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлж гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэх болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэгтэйг эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЕРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Б. Н. Н.* Ц.НАРАНЧИМЭГ

1/10.10.10.2020/Info KhoroofYasan Bich20210315audit 3-R Qasart Doc

ДОТООД АУДИТ

Дотоод аудитын чиглэлээр 2020 онд дараах үйл ажиллагааг явууллаа.

- Үнэ тариф, зах зээлийн газрын Зах зээлийн судалгаа, хамтын ажиллагааны хэлтсийн чиг үүргийн биелэлтийн байдалд аудит хийж дүгнэлт гарган, зөвлөмж өгөв.
- “Дулааны 4 дүгээр цахилгаан станц” ТӨХК, “Хөдөө аж ахуйн их сургууль” ТБАГУТУГ, “Грийн” ХХК-иудын эрчим хүч хэмнэх үйл ажиллагаанд аудит хийж зөвлөмж өгсөн. Энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах Хорооны даргын тушаал гарч, холбогдох байгууллагуудад үүрэг даалгавар өгч, хяналт тавин ажиллаж байна.
- “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн Нэг худалдан авагчтай загварын хэрэгжилтийн байдал, Төвийн бүсийн эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээний төлөвлөлтийн байдалд аудит хийж 12 дүгнэлт, 5 зөвлөмж гаргав.
- Эрчим хүчний зохицуулах хорооны хэмжээнд мөрдөгдөж буй холбогдох хуулиудын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

- 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Үндэсний Аудитын Газраас ирүүлсэн мэдээллийн дагуу холбогдох нэгжүүдээс нийт 9 төрлийн гүйцэтгэлийн мэдээллийг гаргуулан, хянав. Хөндлөнгийн аудитын зөвлөмжийн дагуу хийгдэж буй ажлын явцад хяналт тавин ажиллаж байна.
- Эрчим хүчний зохицуулах хорооны ажилтан, албан хаагчдад зориулан Эрсдэлийн үнэлгээний чиглэлээр сургалтын материал, мэдээлэл бэлтгэн түгээсэн.

“Эрчим хүчний салбарын зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох”, “Цахилгаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаанд өрсөлдөөн нэвтрүүлэх”, “Цахилгаан дамжуулах сүлжээ” ТӨХК-ийн 2021 онд мөрдөх “Цахилгаан дамжуулалтын алдагдлын үндэслэлийг нягталж үр дүнг танилцуулах”, “Төвийн бүсийн “Нэг худалдан авагч”-тай загварын цахилгаан эрчим хүчний төлбөрийн мөнгөн урсгалыг зохицуулах хувь хэмжээг тогтоох аргачлалыг шинэчлэх” зэрэг ажлын хэсгүүдэд орж ажиллав.


ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Эрчим хүчний зохицуулах хороо нь 2020 оны байдлаар нийт 192 хуулийн этгээдэд 11 нэр төрлийн 317 тусгай зөвшөөрөл олгосон ба тэдгээрийн үйл ажиллагааг эрчим хүчний хууль тогтоомжийн дагуу зохицуулж байна.

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	Олгосон ТЗ-ийн тоо	ТЗЭ хуулийн этгээд
1	Цахилгаан үйлдвэрлэх	24	317 ТЗЭ 144 хуулийн этгээд
2	Дулаан үйлдвэрлэх	27	
3	Цахилгаан түгээх	30	
4	Цахилгаанаар зохицуулалттай хангах	31	
5	Дулаан түгээх	95	
6	Дулаанаар зохицуулалттай хангах	96	
7	Цахилгаан импорт, экспорт	9	48 хуулийн этгээд
8	Цахилгаан дамжуулах	3	
9	Диспетчерийн зохицуулалт хийх	1	
10	Цахилгаанаар зохицуулалтгүй хангах	1	
11	Эрчим хүчний барилга байгууламж барих	56	
Олгосон тусгай зөвшөөрөл		317	
Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд		192	

График 3. Тусгай зөвшөөрөл олголт сунгалт



Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн төрөл

№	Тусгай зөвшөөрлийн төрөл		Олгосон ТЗ тоо	Сунгасан ТЗ тоо	Хүчингүй болгосон ТЗ тоо
1	Цахилгаан үйлдвэрлэх	Уламжлалт эх үүсгүүр	-	1	4
		Сэргээгдэх эх үүсгүүр	1	3	9
2	Дулаан үйлдвэрлэх		-	3	-
3	Цахилгаан дамжуулах		-	-	-
4	Цахилгаан түгээх		3	5	-
5	Цахилгаанаар зохицуулалттай хангах		3	6	-
6	Цахилгаанаар зохицуулалтгүй хангах		-	-	-
7	Дулаан түгээх		2	37	2
8	Дулаанаар зохицуулалттай хангах		2	38	2
9	Диспетчерийн зохицуулалт		-	-	-
10	Цахилгаан импортлох, экспортлох		1	1	1
11	Эрчим хүчний барилга байгууламж барих	Уламжлалт эх үүсгүүр	2	1	-
		Сэргээгдэх эх үүсгүүр	1	3	-
		Шугам сүлжээ, дэд станц	-	-	-
		ДС барих өргөтгөх	2	1	-
Дүн			17	99	18

2020 онд эрчим хүчний үйл ажиллагаа эрхэлж буй 53 хуулийн этгээдийн 99 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 12 хуулийн этгээдэд 17 тусгай зөвшөөрлийг шинээр олгож, 16 хуулийн этгээдийн 18 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭХ ҮҮСГҮҮР

"Дезерт солар пауэр вуан" ХХК-ийн 30 МВт-ын "Говь" нарны цахилгаан станц баригдаж 2020 онд ашиглалтад орсон. Ингэснээр эрчим хүчний системд 3 салхин цахилгаан станц, 6 нарны цахилгаан станц, 4 усан цахилгаан станц тус тус цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж байна.

2020 оны байдлаар 155 МВт-ын нийлбэр чадал бүхий 3 салхин цахилгаан станц 443.05 сая кВт.ц цахилгаан эрчим хүч, 90 МВт-ын нийлбэр чадал бүхий 6 нарны цахилгаан станц 100.1 сая кВт.ц цахилгаан эрчим хүч тус тус үйлдвэрлэж Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд нийлүүлсэн байна.

Сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүр барьж байгуулах тусгай зөвшөөрлийг "Эрдэнэбүрэнгийн

УЦС" ТБАГ-т 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс 5 жилийн хугацаатай олголоо.

Тайлант хугацаанд "Тосонцэнгэл УЦС" ХХК, "Тайшир Гуулин УЦС" ХХК, "Богдын голын УЦС" ХХК-иудын цахилгаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 5 жилээр сунгасан болно.

"Айдинер Глобал" ХХК, "АБ солар винд" ХХК, "Клинтек" ХХК-иудын эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийн хугацааг 5 жилээр сунгаснаас гадна Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.8 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтуудын дагуу "Айдинер Глобал" ХХК-ийн эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулсан юм.

Сэргээгдэх эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийн талаар

2020 оны байдлаар нийт 1324.8 МВт чадал бүхий дараах сэргээгдэх эрчим хүчний барилга байгууламжийг барих тусгай зөвшөөрөл эзэмшигчид байна.

Үүнд:

- 400.4 МВт-ын нийлбэр чадал бүхий 3 салхин цахилгаан станц;
- 489 МВт-ын нийлбэр чадал бүхий 16 нарны цахилгаан станц;
- 235.4 МВт-ын нийлбэр чадал бүхий 5 усан цахилгаан станц;
- 145 МВт-ын нийлбэр чадал бүхий ус хуримтлуурын 2 станц;
- 47.4 МВт-ын нийлбэр чадал бүхий биомассын 2 станц;
- 55 МВт-ын нийлбэр чадал бүхий эрчим хүч

хуримтлуурын 2 станц тус тус байна.

Эрчим хүчний зохицуулах хорооноос 2020 онд сэргээгдэх эрчим хүчний 90 МВт-ын чадал бүхий барилга байгууламж барих 1 тусгай зөвшөөрөл олгож, 400.4 МВт-ын нийлбэр чадал бүхий 3 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зохих ёсоор биелүүлээгүй, тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан 188 МВт-ын нийлбэр чадал бүхий 9 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 30 МВт-ын чадал бүхий 1 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахгүй байхаар шийдвэрлэсэн ба Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтын дагуу 1 тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулсан байна.

График 4. Үйлдвэрлэх хүчин чадлын бүтэц (МВт)





График 5. СЭХ-ний үйлдвэрлэх хүчин чадлын бүтэц (МВт)



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫН МОНИТОРИНГ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Эрчим хүчний зохицуулах хороо нь салбарын үр ашгийг дээшлүүлэх, найдвартай ажиллагааг хангах, эрчим хүчний хангамжийн чанарыг дээшлүүлэхэд өөрийн орны онцлогт тохирсон зохицуулалтыг бий болгох зорилгоор 192 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нөхцөл, шаардлагын биелэлтийг "E-License" цахим системээр авч дүгнэн 2020 онд мөрдөж ажиллах зорилтыг тогтоолоо.

Нийт 314 тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын зорилтыг дүгнэхэд 5.1 хувь нь "Хангалттай сайн", 44.3 хувь нь "Сайн", 36.3 хувь нь "Дунд", 14.3 хувь нь "Хангалтгүй" үнэлгээтэй дүгнэгдсэн байна. Хангалтгүй үнэлгээ авсан тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн дийлэнх хувь нь эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл эзэмшигчид байна.

Тусгай зөвшөөрлүүдийн нөхцөл, шаардлагын 2020 оны зорилтыг шинэчлэн тогтоосон нь дараах үндсэн ач холбогдолтой болно. Үүнд:

- Хэрэглэгчдийг тогтвортой үнэ өртөг бүхий чанарын шаардлага хангасан, эрчим хүчээр хангах, хэрэглэгчдийн тав тухтай амьдарч ажиллах орчныг бүрдүүлэх;
- Ухаалаг сүлжээ, технологийн шийдэл бүхий техникийн шинэчлэлийн ажлыг хэрэгжүүлэх;
- Компанийн санхүү, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, зардлын өсөлтийг бууруулах;
- Эрчим хүч хэмнэх хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу үр ашгийг сайжруулах;
- Хүний нөөцийн албан тушаалын тодорхойлолтод дүн шинжилгээ хийж, ажлын давхардал хийдлийг арилгах зэрэг болно.

2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТ

2020 онд Хорооны даргын удирдамжаар төлөвлөгөөт 6, төлөвлөгөөт бус 4, нийт 10 хяналт шалгалт хийж, шалгалтаар 48 зөрчил илрүүлэн, илэрсэн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Хорооны 6 тогтоолоор 102 үүрэг даалгавар, Эрчим хүчний хяналтын улсын (ахлах) байцаагчийн 8 албан шаардлагаар 49 үүрэг даалгавар, 12 зөвлөмжийг хугацаатай өгч биелэлтэд нь хяналт тавьж ажиллав.

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт:

Хорооны даргын баталсан, 2020 онд тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтэд хийх шалгалтын төлөвлөгөө, хуваарийн дагуу "Баруун бүсийн эрчим хүчний систем" ТӨХК, "Ховд ЦТС" ХХК, "Увс ЦТС" ХХК, "Алтай Улиастай эрчим хүчний систем" ТӨХК, "УСДУ" ОНӨААТҮГ, "Чандмань-Илч" ХХК-иудад шалгалт хийж, нийт 6 аймагт, 22 хоног ажиллаж илэрсэн зөрчлийг арилгуулахаар Хорооны тогтоол болон Эрчим хүчний хяналтын улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд Хорооны даргын шийдвэрээр "Булганмээж" ХХК, "Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ, "Дулааны 4 дүгээр цахилгаан станц" ТӨХК, "Монголын алт МАК" ХХК, "Шинэ Ази групп" ХХК, "Баатар дулаан хан" ХХК-иудад шалгалт хийж холбогдох арга хэмжээг авч ажиллав.

Эрчим хүчний тухай хууль зөрчсөн "Дулааны 4 дүгээр цахилгаан станц" ТӨХК, "Монголын Алт МАК" ХХК, "Диспетчерийн үндэсний төв" ТӨХХК, "Тосонцэнгэл УЦС" ХХК, "Эрчим баян өлгий" ХК, Нийслэлийн хувийн орон сууцны 16 компани, 1 албан тушаалтны зөрчлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу Хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж нийт 23.0 сая төгрөгөөр торгох шийтгэл ногдуулж Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокуророор хянуулж ажиллав.

Зөвлөн туслах үйлчилгээ:

Булган аймгийн "Энержи плас" ХХК, "Дөргөний УЦС" ХХК, "Тайшир Гуулин УЦС" ХХК, "Богдын голын УЦС" ХХК, "Тосонцэнгэлийн УЦС" ХХК, Дорноговь,

Говьсүмбэр аймгуудын Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тусгай зөвшөөрөл эзэмшигч 5 компанид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, Эрчим хүчний хяналтын улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлэв.

Урьд нь хийсэн шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үүрэг даалгаврын биелэлт:

"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-д хийсэн "Гүйцэтгэлийн хяналт"-ын дүн болон "Баянхонгор эрчим хүч цахилгаан түгээх" ХХК, "Хөвсгөл эрчим хүч" ХХК-иудад хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар Хорооны тогтоолоор өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг дүгнэв. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд 2020 онд хэрэгжүүлсэн шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах, ЭХЗХ-ны баталсан үнэ тарифыг мөрдөхгүй байгаа зөрчлийг арилгуулах зэрэг зорилгоор нийт 3 албан тушаалтан, 7 компанид улсын байцаагчийн шаардлага хүргүүлж хэрэгжилтийг хянаж ажиллав.

Хяналт шалгалтаар илэрсэн нийтлэг зөрчлүүд:

2020 онд хэрэгжүүлсэн хяналт шалгалтаар нийтлэг дараах төрлийн зөрчлүүд илэрсэн.

1. Толгой болон охин компаниудын засаглалын байдал тодорхойгүй, компанийн эрхзүйн байдлын болон хөдөлмөрийн харилцааг зохицуулах эрхзүйн баримт бичгүүд нь холбогдох хууль тогтоомжид нийцээгүй, охин компаниудын дүрмийг шинэчлэн батлуулаагүй, хөдөлмөрийн дотоод журам, ажиллагсдад олгох цалин урамшууллын журмыг нэгдсэн байдлаар батлуулж мөрдүүлээгүй;
2. Толгой болон охин компаниудтай байгуулсан цахилгаан эрчим хүч худалдах худалдан авах гэрээ, цахилгаан эрчим хүч хэрэглэгчдийн

төлбөр тооцоог гүйцэтгүүлэхээр Арилжааны банкнуудтай байгуулсан гэрээнүүд нь Тусгай зөвшөөрөл эзэмшигч хоорондын аж ахуйн харилцааны дүрэмд нийцээгүй, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй;

3. Аж ахуй нэгж, байгууллага, ахуйн хэрэглэгчтэй байгуулсан Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээний заалтууд Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч-хэрэглэгч хоорондын "Аж ахуйн харилцааны дүрэм"-ийн биелэлтийг хангахгүй;
4. Хэрэглэгчийн шугам сүлжээг ашиглалтад хүлээж авах шаардлагуудыг мөрдөөгүйгээс хамгаалалтын зурвас зөрчсөн хэрэглэгч нэмэгдэж, гэр хорооллын зарим тоолуурын нэгдсэн самбарын угсралт стандартаар тогтоосон хэмжээнд хийгдээгүй, самбарын газардуулгыг бүрэн хийгээгүй, хэрэглэгч рүү татсан кабель шугам газар дээгүүр ил татагдсан, эсвэл залгаатай зэрэг аюулгүй ажиллагааны болон техник ашиглалтын дүрмийн шаардлагыг биелүүлээгүй;
5. Нэг ба хоёрдугаар зэргийн хэрэглэгчдийг түгээх сүлжээний хувьд сэлгэн залгах техникийн боломжгүй, аваар, саатал, тасралт зэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор аварийн үед ажиллах горим байхгүй, цахилгаан түгээх сүлжээний тоноглолын ашиглалтын байдал хангалтгүй;
6. Хүний нөөцийн бодлогын хүрээнд инженер техникийн ажиллагсдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр үр дүнтэй ажил зохион байгуулдаггүй зэрэг зөрчлүүд нийтлэг байна.

Хяналт шалгалтын үр дүн:

1. 2019-2020 оны халаалтын улиралд Булган аймгийн хэрэглэгчдийн дулаан хангамж доголдох эрсдэл үүссэнтэй холбогдуулан Булган аймгийн дулааны станц, "Булганмээж" ХХК-ийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, шалгалтын мөрөөр Булган аймгийн хэрэглэгчдийн дулаан хангамжийг хариуцан ажиллаж буй "Булганмээж" ХХК-д ЭХЗХ-ноос тусгай зөвшөөрөл олгох, дулааны станцаас "Булганмээж" ХХК-д худалдах дулааны үнийг батлах зэрэг ажлуудыг хэрэгжүүлэв.
2. "Баруун бүсийн эрчим хүчний систем" ТӨХК, "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК болон тэдгээрийн охин компаниудад хийсэн

шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг газар дээр нь шалгаж мөн тус компаниудын инженер техникийн ажиллагсдад зориулсан сургалтыг "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-тай хамтран 2020 оны 9 дүгээр сард зохион байгуулсан.

3. Улаанбаатар хотын дулааны хэрэглэгчдийн 50 гаруй хувийг дулаанаар хангах үйл ажиллагааг эрхэлж байгаа "ОСНААУГ" ОНӨААТҮГ-ын үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал их хэмжээгээр нэмэгдсэн, мөн орон тоо тодорхой хувиар нэмэгдэж цалингийн сангийн өөрчлөлтөөс шалтгаалан тус газрын 2020 оны түгээх үйлчилгээний төлбөрт их хэмжээний өөрчлөлт оруулах шаардлага үүссэнтэй холбогдуулан төлөвлөгөөт бус шалгалт хийсэн. Шалгалтаар тус газрын бүтэц, орон тоо, зардлын хуваарилалт, мөнгөний урсгалын зохицуулалт, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тарифт тусгах зэрэг асуудлаар Хорооноос авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж даргын тушаалаар холбогдох нэгжид үүрэг даалгавар өгсөн.
4. Дорноговь аймгийн "Чандмань-Илч" ХХК, Говьсүмбэр аймгийн "УСДУ" ОНӨААТҮГ-т хийсэн шалгалтаар эдгээр компаниудын тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг шалган зохих арга хэмжээг авахын зэрэгцээ дулаан түгээх үйлчилгээний төлбөр буюу тарифын санал боловсруулах, мэдээ тайланг үнэн зөв бэлтгэн ирүүлэх талаар мэргэжил аргагүйн зөвлөмж өгч ажиллав.
5. Хяналт шалгалт хийсэн компаниудын тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын хэрэгжилт, 2020 онд тогтоосон зорилтын биелэлт, тусгай зөвшөөрөл олгогч байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллахад шалгалтын багаас өгсөн мэргэжлийн зөвлөмжүүд тодорхой үр дүнд хүргэх болно.
6. Хяналт шалгалтад ижил төрлийн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байгаа компаниудыг хамруулж компанийн засаглалын байдал, удирдлага зохион байгуулалт, бүтэц орон тооны оновчтой байдал, мэргэжилтэй боловсон хүчний хүрэлцээ зэргийг харьцуулан дүгнэлт гаргаж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллахыг чухалчилсан.
7. Эрчим хүчний тухай хууль болон холбогдох дүрэм журам, тусгай зөвшөөрөл олгогч байгууллагын шийдвэрийг зөрчсөн зөрчлүүдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авч цаашид давтан гаргахгүй байх тал дээр анхаарч ажилласан юм.

ҮНЭ ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТ

Эрчим хүчний зохицуулах хороо нь дэлхий нийтийг хамарсан цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор улс орны хэмжээнд өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэний улмаас тулгарч буй санхүү, эдийн засгийн хүндрэл, үнэ тарифын хязгаарлагдмал нөхцөл байдлын хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч хоорондын дотоод тарифын оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлэхэд гол анхаарал хандуулж ажилласан.

Цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ тарифын аргачлал болон тарифын зохицуулалттай холбоотой бусад аргачлал, журмууд, үнэ тарифын загварын өнөөгийн байдлын талаар холбогдох судалгааг хийж, олон улсын нийтлэг жишгийн дагуу бодит өртөг, ашгийн зохих түвшинг хангасан, “урамшуулалд суурилсан”, “ирээдүйд чиглэсэн” дунд хугацааны тогтвортой бөгөөд индексжүүлэлт бүхий тарифын тогтолцоонд үе шаттай шилжих талаар санал боловсруулсан бөгөөд 2021 онд энэхүү тарифын тогтолцоонд шилжих бэлтгэл ажлыг хангахаар төлөвлөж байна.

Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор Нийслэл хот болон аймгийн төв, арван мянгаас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын айл өрхийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифт хөнгөлөлт үзүүлж эхэлснээс хойших хугацаанд цахилгаанаар зохицуулалттай хангах зарим тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд нэгдсэн хяналт, шалгалт хийж, илэрсэн зөрчлүүдийг арилгах, үйл ажиллагаа сайжруулах талаар санал дүгнэлтийг боловсруулж, холбогдох чиглэлээр зөвлөмж шаардлагыг өгч байлаа.

Төвлөрсөн дулаан хангамжтай аймгийн төв, суурин газарт дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын найдвартай ажиллагааг хангах, санхүү, эдийн засгийн чадавхыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, дулаан хэрэглэгч айл өрх болон аж ахуйн нэгж, байгууллагын үнэ тарифын хэт ялгаатай байдлыг арилгах, эрчим хүчний хэмнэлтийн үр ашгийг үйлдвэрлэх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч ба хэрэглэгчдэд зохистой байдлаар хуваарилахад чиглэсэн үнэ тарифын нийтлэг жишиг, загварыг боловсруулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор айл өрхийн болон зарим аж ахуйн нэгж, байгууллагын хэрэглэсэн цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын төлбөрийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөх шийдвэр гарсан тул холбогдох тооцоо, судалгаа, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлох, Эрчим хүчний зохицуулах хороо болон аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүдийн нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төлбөр тооцооны урьдчилгаа болон гүйцэтгэлийн мэдээллийг нэгтгэн хянах арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, шимтгэлийн дүн 2019 онд 335.0 тэрбум төгрөг байсан бол 2020 онд 386.5 тэрбум төгрөг болж нэмэгджээ.

ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭ, ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 62 дугаар тогтоолоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлснээс хойш хугацааг удаа дараа сунгаж, бэлэн байдлын зэргийг улс орон даяар болон хэсэгчилсэн байдлаар өөрчлөн тогтоож ирсэн. 2020 онд хэрэглэгчдэд борлуулах цахилгаан, дулааны үнэ тарифыг индексжүүлэх, өөрчлөлт оруулах талаар тооцоо судалгаа, холбогдох саналыг боловсруулсан боловч Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан “бүтээгдэхүүний үнийн хөөрөгдөл үүсэхээс сэргийлэх, эдийн засгийн тогтвортой байдлыг

хангахад чиглэсэн арга хэмжээ авах” үүргийн дагуу Зохицуулах хороонд эрчим хүчний үнэ тарифт өөрчлөлт оруулах боломж бүрдээгүй юм.

Мөн энэ хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 114 дүгээр тогтоолоор цахилгааны хэрэглэгч айл өрхүүдийн хэрэглээний төлбөрт алданги оногдуулахгүй, төлбөрөө төлөөгүй өрхүүдийн цахилгааныг хязгаарлах арга хэмжээ авахгүй байх шийдвэр гарч, үүний зэрэгцээ аж ахуйн

нэгж, байгууллагуудын цахилгаан, дулааны хэрэглээ төлөвлөж байснаас 4.3 хувиар буурсан зэрэг нь эрчим хүчний салбар дахь санхүү, эдийн засгийн байдалд сөрөг нөлөө үзүүлж байв.

Эрчим хүчний салбарт тулгарсан нийгэм, эдийн засгийн дээрх хүндрэлтэй нөхцөл байдалд Зохицуулах хороо нь хэрэглэгчийн тарифын зохицуулалтын чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 199 дүгээр тогтоолоор батлагдсан “Гэр хорооллын айл өрхөд цахилгааны тарифын хөнгөлөлт үзүүлэх журам”-д өөрчлөлт орсны дагуу аймгийн төв, арван мянгаас дээш хүн амтай сум суурин газрын айл өрхийн орой, шөнийн хэрэглээний цахилгааны тарифыг 50 хувиар хөнгөлж байсныг 100 хувиар тооцож хөнгөлөлт үзүүлэх шийдвэрийг гаргаснаар Улаанбаатар хотод 117 мянган айл өрх, 21 аймгийн төв, Сэлэнгэ аймгийн Мандал, Өвөрхангай аймгийн Хархорин, Дорноговь аймгийн Замын-Үүд зэрэг 10 мянгаас дээш хүн амтай сум, суурин газруудад 72 мянган айл өрх, нийт 189 мянган гэр хорооллын айл өрх 100 хувийн цахилгааны тарифын хөнгөлөлтөд хамрагдах боломжтой болсон.
- Монгол Улсын Засгийн газрын “Өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 324 дүгээр тогтоолын дагуу цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон, цагийн ялгаварт тарифт тоолууртай өвлийн хүлэмжийн аж ахуйн шөнийн цагт хэрэглэсэн /шөнийн 22.00 цагаас өглөөний 6.00 цаг хүртэл/ цахилгааны тариф болон дэмжих тарифыг жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд 100 хувиар хөнгөлөлт үзүүлэх шийдвэрийг гарган 2019, 2020 онд шаардлагатай санхүүжилтийн тооцоо судалгааг хийж, улсын төсөвт тусгах асуудлыг хариуцан ажилласан.
- Нийслэл болон аймгуудын төв, 10,000-аас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын айл өрхийн орой, шөнийн цахилгааны хэрэглээний

тарифын хөнгөлөлтөөс үүсэх 18.0 тэрбум төгрөгийн санхүүгийн дутагдлыг Улсын төсвийн санхүүжилтээр шийдвэрлүүлэв.

- Хэрэглэгчдэд ирэх ачааллыг зохистой хэмжээнд хөнгөлөх зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд шаардагдах үнэ тарифын алдагдалтай холбоотой татаасыг тооцож, Улсын төсвөөс олгох асуудлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудад танилцуулсан ба орон нутгийн 9 тусгай зөвшөөрөл эзэмшигчид олгох 24.7 тэрбум төгрөгийн татаас улсын төсөвт тусгагджээ.
- Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн дагуу хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг түгээх сүлжээнд холбох, цахилгаан эрчим хүч нийлүүлэх үнэ тарифын загварыг боловсруулаад байна.
- Байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн хэмнэлттэй бүх төрлийн цахилгаан тэжээлт автомашины хэрэглээг дэмжих зорилгын хүрээнд цахилгаан цэнэгт автомашин цэнэглэгч станцад борлуулах цахилгааны тарифын ангилал бий болгож, холбогдох үнэ тарифуудыг тогтоон батлаад байна.

Цахилгааны борлуулалтын дундаж үнэ 2019 оны гүйцэтгэлээр 169.24 төг/кВт.ц байсан бол 2020 онд 176.13 төг/кВт.ц болж нэмэгдлээ. Айл өрхөд борлуулах цахилгааны тариф бодит өртгөөс доогуур түвшинд буюу нэгж кВт.ц тутамд 46.29 төгрөгийн хөнгөлөлтийг айл өрхүүд авч байна.

Энгийн тоолууртай айл өрхөд борлуулах цахилгаан эрчим хүчний тариф 2020 онд дунджаар 150 кВт.ц хүртэлх хэрэглээнд 134.28 төг/кВт.ц, 151 кВт.ц-аас дээших хэрэглээнд 154.08 төг/кВт.ц байсан бөгөөд цахилгааны нэгжийн өртгөөс 18.3-28.8 хувиар доогуур, мөн цагийн ялгаварт тарифт тоолууртай айл өрхөд борлуулах цахилгаан эрчим хүчний тариф өдрийн хэрэглээнд /өглөөний 06.00 цагаас шөнийн 21.00 цаг хүртэл/ 140.18 төг/кВт.ц, оройн шөнийн хэрэглээнд /оройн 21.00 цагаас шөнийн 06.00 цаг хүртэл/ 112.98 төг/кВт.ц буюу 25.7-40.1 хувиар доогуур түвшинд байна. Эрчим хүчний салбарын хэмжээнд айл өрхөд борлуулсан цахилгааны тарифт 80.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлтийг хөндлөн татаасаар үзүүлсэн байна.



Хүснэгт 3. Хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тариф /НӨАТ-гүй/

№	Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Төв, Өмнөд, (дэмжих тариф 23.79 төг/кВт.ц-ийг тусгасан)	Зүүн бүс	Алтай-Улиастайн бүс (дэмжих тариф 11.88 төг/кВт.ц-ийг тусгасан)	Баруун бүс (дэмжих тариф 11.88 төг/кВт.ц-ийг тусгасан)
Уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэр						
1	Энгийн тоолууртай	төг/кВт.ц	179.69	155.90	163.48	163.48
2	3 тарифт тоолууртай					
	а. Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 17.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	179.69	155.90	163.48	
	б. Оройн хэрэглээ /оройн 17.00 цагаас шөнийн 22.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	299.79	276.00	283.58	
	в. Шөнийн хэрэглээ /шөнийн 22.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	100.89	77.10	84.68	
3	Чадлын	төг/кВт/сар	25,000.0	25,000.0	25,000.0	25,000.0
Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага						
1	Энгийн тоолууртай	төг/кВт.ц	164.38	140.59	160.08	160.08
2	3 тарифт тоолууртай					
	а. Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 17.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	164.38	140.59	160.08	
	б. Оройн хэрэглээ /оройн 17.00 цагаас шөнийн 22.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	245.68	221.89	241.38	
	в. Шөнийн хэрэглээ /шөнийн 22.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	112.98	89.19	108.68	
3	"Цахилгаан тээвэр" ХК	төг/кВт.ц	112.98	89.19		
4	Улаанбаатар хот, аймгийн төвийн нийтийн зориулалттай зам талбайн гэрэлтүүлэг болон нийтийн зориулалттай орон сууцны орцны гэрэлтүүлэг					
	10, 11, 12, 1, 2, 3 дугаар саруудад					
	а. Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 19.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	164.38	140.59	160.08	
	б. Орой, шөнийн хэрэглээ /оройн 19.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	112.98	89.19	108.68	
	4, 5, 6, 7, 8, 9 дүгээр саруудад					
	а. Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 22.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	164.38	140.59	160.08	
	б. Орой, шөнийн хэрэглээ /оройн 22.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	112.98	89.19	108.68	
5	Цахилгаан тэжээлт автомашин цэнэглэгч станц					
	3 тарифт тоолууртай	төг/кВт.ц	179.69	155.90	163.48	163.48
	а. Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 17.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	179.69	155.90	163.48	163.48
	б. Оройн хэрэглээ /оройн 17.00 цагаас шөнийн 22.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	299.79	276.00	283.58	283.58
	в. Шөнийн хэрэглээ /шөнийн 22.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	100.89	77.10	84.68	84.68
6	Чадлын	төг/кВт/сар	9,000.0	9,000.0	9,000.0	9,000.0
Айл өрх						
1	2 тарифт тоолууртай					
	а. Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 21.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	140.18	116.39	135.88	122.68
	б. Оройн хэрэглээ /оройн 21.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	112.98	89.19	108.68	
2	Энгийн тоолууртай					
	а. Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц хүртэл хэрэглээг	төг/кВт.ц	134.28	110.49	129.98	122.68
	б. Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц болон түүнээс дээш хэрэглээг	төг/кВт.ц	154.08	130.29	149.78	
3	Ахуйн тоолуургүй хэрэглэгчдийн төлбөр тооцох сарын дундаж хэрэглээ	кВт.ц	350.0	350.0	350.0	350.0
4	Эмзэг бүлгийн хэрэглэгчдийн тариф					
	а. УБ -100 кВт.ц, Дархан, Эрдэнэт -75 кВт.ц, Бусад -50 кВт.ц хүртэл	төг/кВт.ц	84.08	60.29	72.17	72.17
	б. УБ -101 кВт.ц, Дархан, Эрдэнэт -76 кВт.ц, Бусад -51 кВт.ц-аас дээш	төг/кВт.ц	105.18	81.39	93.27	93.27
5	Сарын суурь	төг/сар	2,000.0	2,000.0	2,000.0	2,000.0

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТ

Улсын орны хэмжээнд бэлэн байдлын зэрэгт шилжсэний улмаас тулгарсан эдийн засгийн хүндрэлтэй байдал, хэрэглэгчийн үнэ тарифт өөрчлөлт ороогүй нөхцөлд тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эдийн засаг, санхүүгийн хэвийн үйл ажиллагааг хангах, Төвийн бүсийн “Нэг худалдан авагчтай загвар”-ын алдагдлыг бууруулах зэрэг зорилгоор дотоод тарифын зохицуулалтуудыг хийж ажиллалаа.

Тухайлбал, 2020 онд тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудад хөрөнгийн эх үүсвэртэй холбоотойгоор 133 удаагийн тарифын зохицуулалт хийж, эдгээр зохицуулалтын хүрээнд эрчим хүчний эх үүсвэрүүдэд 50.0 тэрбум төгрөг, цахилгаан дамжуулах, түгээх сүлжээ, диспетчерийн үндэсний төвд 8.6 тэрбум төгрөг, дулааны сүлжээ болон орон сууц, нийтийн аж ахуйн компаниудад 2.6 тэрбум төгрөг, нийт 64.9 тэрбум төгрөгийн орлогын эх үүсвэрийг шийдвэрлэж, санхүүгийн чадавхыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.

Мөн “Нэг худалдан авагчтай загвар”-ын арилжаанд үүссэн 40.0 тэрбум төгрөгийн алдагдлыг бууруулах зорилгоор 3, 4 дүгээр улиралд ОХУ-аас худалдан авах импортын цахилгааны болон чадлын хэмжээг багасгах, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мөнгөн урсгалд нөлөөлөхгүй байдлаар худалдан авах цахилгааны өртгийг бууруулах, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдээс худалдан авах өндөр үнэтэй

цахилгаан эрчим хүчний хэмжээг тарифт тусгагдсан хэмжээтэй уялдуулан бууруулах зэрэг олон арга хэмжээ авч хэрэгжүүлсний дүнд тайлант хугацаанд алдагдалгүй ажилласан.

Дээрх нөхцөл байдалтай уялдуулан эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд нь тоног төхөөрөмжийн эрсдэлийг бодитой үнэлэн зарим хөрөнгө оруулалт, шинэчлэлийн ажлуудыг хойшлуулах, цуцлах, үйл ажиллагааны зардлуудыг хэмнэх, зардал өсгөх чиглэлээр аливаа шийдвэрүүдийг гаргахгүй байх, цахилгаан, дулааны түгээлтийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, улмаар бизнес төлөвлөгөө, зорилтод түвшний үзүүлэлтүүдэд тодотгол хийх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл эзэмшигч цэнэг хуримтлуур болон хатуу хог хаягдлаас цахилгаан үйлдвэрлэх нийт 2 эх үүсвэрийн цахилгааны үнэ, тарифыг Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд заасны дагуу тогтоосон байна.

Мөн Эрчим хүчний тухай хуулийн дагуу “Шарын гол” ХК, “Могой гол” ХК, “Бэрх уул” ХХК, “Цэцэнс майнинг энд энержи” ХХК, “Талын гал” ХК зэрэг төвийн бүсийн болон орон нутгийн цахилгаан, дулааны эх үүсвэрт нүүрс нийлүүлж буй уурхайнуудын нүүрсний үнийн тооцоог хянан шийдвэрлэсэн.

График 6

Төв, Өмнөд бүсийн уул уурхайн хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тариф, төг/кВт.ц /Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тариф тусгасан/




График 7

Төв, Өмнөд бүсийн УААНБ-д борлуулах цахилгааны тариф, төг/кВт.ц /Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тариф тусгасан/



График 8

Айл өрхөд борлуулах цахилгааны тариф, төг/кВт.ц
/Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тариф тусгасан/




/Энгийн тоолууртай/

Дэмжих тариф
151 кВт.ц-аас дээш
хэрэглээтэй айл өрх
150 кВт.ц хүртэл
хэрэглээтэй айл өрх

График 9

Айл өрхөд борлуулах цахилгааны тариф, төг/кВт.ц
/Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тариф тусгасан/



/Тарифт тоолууртай/

Дэмжих тариф
Шөнийн хэрэглээ
/21:00-06:00 цаг/
Өдрийн хэрэглээ
/06:00-21:00 цаг/

График 10

Баруун бүсийн цахилгааны тариф, төг/кВт.ц
/Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тариф тусгасан/




График 11

Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын
орон сууцны халаалт, төг/м²




График 12

Орон сууцны хэрэгцээний халуун ус халаасан дулаан, төг/хүн





График 13

ААНБ-ын халаалт, төг/м³

Халаалтын бус улиралд
Халаалтын улиралдЭрдэнэт
Дархан
Улаанбаатар

Хүснэгт 4. Хэрэглэгчдэд борлуулах дулааны тариф /НӨАТ-гүй/

Нэр	Айл өрхийн халаалт					Хэрэгцээний халуун ус халаасан дулаан			Хэмжүүрээр тооцох дулаан, төг/ГЖ		
	Халаалт, төг/м²	Ахуйн хэрэглэгчийн дулааны үйлчилгээний тариф, төг/сар			ААНБ төг/м³	Хал. улирал	Хал. бус улирал	Усны зарцуулалт, төг/м³	Айл өрхийн халаалт	ААНБ-ын халаалт	Технологийн уур
		40 м²	40-80 м²	81 м²-аас дээш							
Улаанбаатар	506	3,300	5,500	11,000	472	1,870	2,806	1,632	3,421	7,277	5397
Дархан	506	3,300	5,500	11,000	470	1,870	2,806	2500	3,421	6,419	5,360-6,569
Эрдэнэт	506	3,300	5,500	11,000	504	1,870	2,806	2500	3,421	7,854	8,533
Дорнод	506	3,300	5,500	11,000	769	1,870	2,806		3,421	6,698	
Даланзадгад	506	3,300	5,500	11,000	961	1,870	2,806			20,843	
Налайх	600	3,000	5,000	10,000	860-1,290	2,875	4,025	5,000		25,813	
Багануур	660	3,300	5,500	11,000	1,145-1,239	3,163	4,428	1,632	8,711	18,310-19,795	
Архангай	810				2,044						
Баян-Өлгий	780				1,170-1,411	1,170	1,170			31,049	
Говь-Алтай	560				1,800					16,719	
Шарын гол	576	3,000	5,000	10,000	1,500-1,870	1,892	4,025	1,039-1,559		26,798	
Дорноговь	350	3,000	5,000	10,000	990-1,188	3,000	3,000	2,000		19,542	
Дундговь	500				1,600					17,145	
Сүхбаатар	560	3,000	5,000	10,000	1,080-1,900			3,000		47,120	
Сэлэнгэ	486.5				2,166	2,552	13,636 /өрх/		9,075	30,954	
Хөтөл	506				1,093-1,292.2	1,870	2,806			24,804	
Төв	455				1,020-1,900	1,958	1,958	1,300		29,874	
Ховд	500				1,350-1,650	6,000	6,000	2,500	8,957	25,485	
Хөвсгөл	400				850-1,560	6,000	6,000	3,000		28,661	
Хэнтий	620				1,300-1,500	3,000	3,000	3,000		23,884	
Увс	390				850-1,700	2,420	2,420	1,980		19,107	

ЦАХИЛГААНЫ СПОТ ЗАХ ЗЭЭЛ

Спот зах зээл нь цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн диспетчерийн графикийн төлөвлөлт ба бодит нийлүүлэлтийн зөрүүн дээр үүсгэсэн зах зээл юм.

Спот зах зээлийг ажиллуулснаар дулааны цахилгаан станцууд диспетчерийн графикийн зөрчил, доголдол гаргахгүй байх, гаргасан тохиолдолд зах зээлийн зарчмаар эдийн засгийн хариуцлага хүлээх бөгөөд энэхүү арилжаанд оролцогч хоёр үйлдвэрлэгчийн энергийн тарифын зөрүүгээр худалдах арилжаа хийгддэг болно. Спот зах зээл дээр 2020 онд 202.4 сая төгрөгийн өртөг бүхий 4,578.4 мянган кВт.ц цахилгаан эрчим

хүчний арилжаа үйлдвэрлэгчдийн хооронд хийгдсэн байна. Тайлант хугацаанд Спот зах зээл дээр “Дулааны 4 дүгээр цахилгаан станц” ТӨХК 150.2 сая төгрөгийн, “Дулааны 3 дугаар цахилгаан станц” ТӨХК 21.4 сая төгрөгийн ашигтай, “Дулааны 2 дугаар цахилгаан станц” ТӨХК 8.4 сая төгрөгийн, “ДДЦС” ТӨХК 16.9 сая төгрөгийн, “ЭДЦС” ТӨХК 1.5 сая төгрөгийн “Эрдэнэт үйлдвэр ДЦС” 18.9 сая төгрөгийн, Ухаахудагийн цахилгаан станц 59.6 сая төгрөгийн, “ДзДЦС” ТӨХК 44.8 сая төгрөгийн хариуцлага хүлээж ажилласан байна. Спот зах зээл дээрх өглөг, авлага оны эхний үлдэгдлээс 27.8 сая төгрөгөөр буурсан байна.

НЭГ ХУДАЛДАН АВАГЧТАЙ ЗАХ ЗЭЭЛ

Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний цахилгаан эрчим хүчний арилжаа “Нэг худалдан авагч”-тай зах зээлийн загварын хүрээнд хийгдэж байна. Нэг худалдан авагч нь төвийн бүсийн 5 дулааны цахилгаан станц, Ухаахудагийн цахилгаан станц, Эрдэнэт үйлдвэр дулааны цахилгаан станц, Даланзадгадын дулааны цахилгаан станц болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрүүд болох “Клин энерги” ХХК, “Клин энерги ази” ХХК, “Сайншанд салхин парк” ХХК зэрэг салхин цахилгаан станц, “И Эс Би солар энерги” ХХК, “Солар пауэр интернэйшнл” ХХК, “Эвридэй Ферм” ХХК, “Нарантээг” ХХК, “Тэнүүнгэрэл констракшн” ХХК, “Дезерт солар пауэр вуан” ХХК компаниудын нарны цахилгаан станцуудаас, мөн ОХУ-аас цахилгаан эрчим хүч импортоор худалдан авч төвийн бүсийн 20 цахилгаан түгээх компани болон “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-д борлуулдаг бөгөөд Нэг худалдан авагчийн үүргийг “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК хэрэгжүүлж байна.

Төвийн бүсийн хэрэглэгчдээс цуглуулсан цахилгааны орлогыг арилжааны банкнуудад байршуулсан “Тэг үлдэгдэлтэй орлогын данс”-аар урьдчилан тогтоосон хувь хэмжээний дагуу үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгч компаниудын дансанд өдөр бүр хуваарилдаг ба энэхүү хувь


хэмжээг эрчим хүчний төлбөрийн мөнгөний урсгалын зохицуулалтад хамрагдагч 22 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөөлөл оролцсон “Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хурал”-аар хэлэлцэн тогтоож, мөрдөж байна.

Нэг худалдан авагч нь 2020 онд 4,987.2 сая кВт.ц цахилгааныг төвийн бүсийн 5 дулааны цахилгаан станцаас, 451.2 сая кВт.ц цахилгааныг салхин цахилгаан станцуудаас, 104.2 сая кВт.ц цахилгааныг нарны цахилгаан станцуудаас, 296.7 сая кВт.ц цахилгааныг Ухаа худаг, Даланзадгад, Эрдэнэт үйлдвэрийн дулааны цахилгаан станцуудаас, 186.9 сая кВт.ц цахилгааныг ОХУ-аас импортоор авсан ба 6,026.1 сая кВт.ц цахилгааныг цахилгаан түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудад худалдаж, 39.9 сая кВт.ц цахилгааныг экспортолсон байна. Өмнөх оны гүйцэтгэлээс худалдан авсан цахилгааны эрчим хүч 1.3 хувиар, дундаж үнэ 1.9 хувиар, худалдсан цахилгааны эрчим хүч 1.0 хувиар, дундаж үнэ 4.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

2020 оны дүнгээр цахилгаан түгээх компаниуд Нэг худалдан авагчид нийт худалдан авсан цахилгааны төлбөрийн 96.8 хувь буюу 790.4 тэрбум төгрөгийг төлж, Нэг худалдан авагч нь цахилгаан станцуудаас болон импортоор худалдан авсан цахилгаан эрчим хүчний төлбөрийн 97.8 хувийг төлж барагдуулсан байна.

График 14

Нэг худалдан авагчтай загварын орлого төвлөрүүлэлт



Түгээх, хангах ТЗЭ

Үйлдвэрлэх, дамжуулах ТЗЭ

ЦАХИЛГААНЫ ӨРСӨЛДӨӨНТ ЗАХ ЗЭЭЛ

Төвийн бүсийн хэмжээнд 2020 оны 01 дүгээр сард хэрэглээний өсөлт гараагүй боловч импортын цахилгаан эрчим хүчийг хэмнэх зорилгоор эх үүсвэрүүдийн дунд 10.0 сая.кВт.ц цахилгаан эрчим хүчний багцын арилжааг зохион байгуулсан. Зарлагдсан энергийн багцад хамгийн бага үнийн санал ирүүлсэн "Дулааны 4 дүгээр цахилгаан станц" ТӨХК 10.0 сая кВт.ц энергийн

багцыг 53.0 төг/кВт.ц үнээр худалдахаар ялагч болон шалгарснаар 530.0 сая.төг-ийн ашигтай ажилласан байна.

2020 оны 02 дугаар сараас эхлэн улс орны хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнээр хэрэглээнд өсөлт гараагүй тул өрсөлдөөнт зах зээл дээр арилжаа хийгдээгүй.



ХЭРЭГЛЭГЧИЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН НАЙДВАРТАЙ БАЙДАЛ

Хэрэглэгчдийн цахилгаан хангамжийн тасалдлыг олон улсын хэмжээнд мөрддөг индексүүдийг ашиглан тооцож байна. Үүнд;

1. Системийн цахилгаан тасалдлын дундаж хугацааны индекс /SAIDI-System average interruption duration index/ нь жилд нэг хэрэглэгчид ногдож буй тасалдлын үргэлжлэх дундаж хугацаа;
(минут/тасарсан хэрэглэгч/жил)
2. Системийн цахилгаан тасалдлын дундаж тохиолдлын индекс /SAIFI-System average interruption frequency index/ нь жилд нэг хэрэглэгчид ногдож буй тасалдлын тоо;
(тасралт/тасарсан хэрэглэгч/жил)
3. Тасарсан хэрэглэгчдийн тасалдлын дундаж хугацааны индекс /CAIDI-Customer average interruption duration index/ нь жилд тасалдалд

хамрагдсан хэрэглэгчид ногдох тасалдлын үргэлжлэх дундаж хугацаа;


(минут/тасарсан хэрэглэгч/жил)

Хэрэглэгчийн цахилгаан хангамжийн тасалдлын хэмжээг дээр дурьдсан 3 индексийг ашиглан улирал бүрээр гаргаж, дүгнэж ажиллалаа. Ингэхэд индексүүдийг цахилгаан түгээх компани бүрээр, мөн төлөвлөгөөт тасалдал, хангагчийн буруутай үйл ажиллагаа, байгалийн гамшиг, бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн буруу зэрэг шалтгаан бүрээр ангилан гаргаж байна.


Улсын хэмжээнд 2020 онд нэг хэрэглэгчид 42 цагийн тасалдал ногдож байгаа нь өмнөх оноос 12 цагаар буурчээ. Түүнчлэн нэг хэрэглэгчид ногдож буй тасалдлын тоо 8 болж өмнөх оноос 1 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна. Төвийн бүсийн дүнгээр тасалдлын үргэлжлэх хугацаа 15 цагаар буурсан нь нийт дүнд эерэг нөлөө үзүүлсэн байна.

График 15. Тасалдлын индекс


И саиди, цаг



И саифи, тоо



И каиди, цаг



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төвийн бүсийн нэгдсэн сүлжээ (ТБНС)-ний 7 дулааны цахилгаан станцын дүнгээр 2020 онд дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчний хувь хэмжээг өмнөх оны гүйцэтгэл 13.6 хувиас 0.3 нэгжээр буюу 20.4 сая кВт.ц цахилгаанаар хэмнэжээ. Үүнд "Дулааны 4 дүгээр цахилгаан станц" ТӨХК-ийн 89 МВт-ын өргөтгөл ашиглалтад орж станцын суурилагдсан хүчин чадал нэмэгдсэн нь нөлөөлсөн.

Эрчим хүчний зохицуулах хороо нь 2002 оноос эхлэн цахилгаан станцуудын дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчийг бууруулж, хэмнэлт гаргах талаар жил бүр зорилт дэвшүүлж ажилласан ба

энэхүү зорилтыг биелүүлэхэд дулааны цахилгаан станцуудын зүгээс техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлснээр станцуудын дотоод хэрэгцээнд зарцуулж буй цахилгааны хувь хэмжээ буурсан дүнтэй байна.

Харин 2020 онд "ДБЭХС" ТӨХК дотоод хэрэгцээний цахилгаанаа 0.28 нэгжээр хэтрүүлж 649.3 мянган кВт.ц цахилгаан эрчим хүчийг илүү зарцуулсан нь тус бүс нутгийн хэрэглээний бууралттай холбоотойгоор нэгж тоноглолын дундаж цахилгаан ачаалал буурснаас шалтгаалсан байна.

График 16. ТБНС-ний дулааны цахилгаан станцуудын дотоод хэрэгцээний цахилгааны зарцуулалт /хувиар/






График 17. Дулааны цахилгаан станцуудын жишмэл түлшний хувийн зарцуулалт



Төвийн бүсийн нэгдсэн сүлжээ (ТБНС)-ний 7 дулааны цахилгаан станцуудын дүнгээр 2020 онд цахилгаанд 315.6 гр/кВт.ц, дулаанд 177.4 кг/Гкал жишмэл түлш зарцуулсан нь өмнөх оны

гүйцэтгэлээс цахилгаанд 6.8 гр/кВт.ц-аар, дулаанд 2.3 кг/Гкал-аар тус тус буурч, нийт дүнгээрээ 54.8 мянган тн жишмэл түлш буюу 114.8 мянган тн нүүрс бага зарцуулжээ.

График 18. ТБНС-ний цахилгаан дамжуулалт, түгээлтийн алдагдал (Хувиар)



Цахилгаан түгээлтийн алдагдлыг 2019 онтой харьцуулахад "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК 0.26 нэгжээр, "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК 2.68 нэгжээр, "Дархан сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ" ХК 1.02

нэгжээр тус тус бууруулсан байна. Харин "Цахилгаан дамжуулах сүлжээ" ТӨХК 0.28 нэгжээр, "Эрдэнэт, Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК 0.21 нэгжээр алдагдлыг нэмэгдүүлсэн нь цахилгаан дамжуулалт, түгээлтийн нийт алдагдалд сөргөөр нөлөөлсөн.

Хүснэгт 5. Дулааны цахилгаан станцуудын үндсэн тоноглолын ажиллагаа

ТЗЭ	Зуухны дугаар	Тасралтгүй ажилласан хугацаа		Турбины дугаар	Тасралтгүй ажилласан хугацаа	
		цаг	хоногоор		цаг	хоногоор
ДЦС-2 ТӨХК	К-5	3600	150	ТГ-3	2160	90
ДЦС-3 ТӨХК	К-9	4407	184	ТГ-1	5433	226
ДЦС-4 ТӨХК	К-5	3133	131	ТГ-4	5315	221
ДДЦС ТӨХК	К-5	1919	80	ТГ-3	2029	85
ЭДЦС ТӨХК	К-5	2616	109	ТГ-1	4414	184
Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	К-3	2568	107	ТГ-6	2712	113
ДэдЦС ТӨХК	К-1	1132	47	ТГ-2	2976	124
ДБЭХС ТӨХК	К-5	3024	126	ТГ-1	4632	193
MCS international ХХК	К-2	2081	87	ТГ-2	3674	153

ХЭРЭГЛЭГЧИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ

Хороонд 2020 онд нийт 4614 хэрэглэгчийг хамаарсан 278 өргөдөл бичгээр ирсэн бөгөөд үүний 38 хувь буюу 106 нь иргэнээс, 24 хувь буюу 66 нь тусгай


зөвшөөрөл эзэмшигчээс, 16 хувь буюу 46 нь СӨХ-ноос, 18 хувь буюу 49 нь аж ахуйн нэгжээс, 4 хувь буюу 11 нь төрийн байгууллагаас хандсан байна.



Хэрэглэгч
4614



Өргөдөл бичгээр
278



Цахилгааны эрчим хүчтэй холбоотой гомдлуудын хувьд:


Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу бичгээр хандсан 125 хэрэглэгчээс гадна дараах хэлбэрүүдээр гомдол маргааныг хүлээн авч шийдвэрлэн, шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж, зөвлөмж зөвлөгөө өгч ажилласан. Үүнд:



Хэрэглэгчдийн гомдлыг хүлээн авч, хянаж шалган ЭХЯ, ШӨХТГ, ИХАШШүүх, АТГ, УБЗАА, АНЗЗ нийт 30 хэрэглэгчийн гомдлыг шилжүүлж, 3 чиглэлээр тайлбар тодруулга авч, 3 удаа уулзалт зөвлөгөөнд оролцож хамтран ажиллав.

Засгийн газрын 11-11 төвд Хорооны харьяалан шийдвэрлэх асуудлаар нийт 43 санал хүсэлт ирүүлснийг холбогдох арга хэмжээг авч хариуг хүргүүлсэн.

Цахилгаан эрчим хүчтэй холбоотойгоор:



Мөн тусгай зөвшөөрөлгүй цахилгааны борлуулалтын үйл ажиллагаа эрхэлж байсан 5 аж ахуйн нэгжийн хууль зөрчсөн үйл ажиллагааг зогсоосноор нийт 472 айл өрх цахилгаан эрчим хүчээр хангах гэрээг тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулан ажиллаж байна.

Эрчим хүчний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 28 дугаар зүйлийн 28.1, 32 дугаар зүйлийн 32.2.1 дэх заалтыг зөрчсөн "Ач-Очир" ХХК-ийг Зөрчлийн тухай хуулийн 12.8 дугаар зүйлийн 1.1 дэх заалтыг үндэслэн 2.5 сая төгрөгөөр торгож, нийт 128 айл өрхийн цахилгааны борлуулалтын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх арга хэмжээ авч, зөрчлийг арилгуулсан.

Иргэний хэргийн анхан шатны шүүхээс урьдчилан шийдвэрлүүлэх арга хэмжээ авахуулахыг мэдэгдсэн 9 хэрэглэгчийн төлбөрийн тооцооллыг шалгаж, илэрсэн зөрчлүүдийн талаар 2 талын уулзалтыг зохион байгуулж, цахилгааны төлбөр, хангамжтай холбоотой 28 хэрэглэгчийн өргөдлийг газар дээр нь шалгаж, маргааныг эцэслэн шийдвэрлэсэн.

Цахилгаан түгээх, хангах 27 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 2019 оны ТЗНШ-ын биелэлтэд хэрэглэгчийн эрх ашгийг хангахтай холбоотой

нөхцөл, шаардлагын биелэлтийг дүгнэв.

Цахилгаан эрчим хүчтэй холбоотой дараах нийтлэг зөрчил гарч байна. Үүнд:

- Айл өрхийг ААН-ийн тарифаар тооцсон;
- Дэд станц шугам тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигч мэргэжлийн байгууллагад хүлээлгэж өгөхгүй байх;
- Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд гэр хорооллын айл өрхүүдийн халаалтыг цахилгаанаар шийдэж, шөнийн хөнгөлөлт үзүүлж байгаатай холбоотой гэр хорооллын 0.4 кВ-ын шугам сүлжээний хүчдэлийн түвшин стандарт шаардлага хангахгүй түвшинд хүрч байгаагаас хэрэглэгчийн гомдол ихэсч байна. Тухайн асуудлаар цахилгаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчид холбогдох арга хэмжээг авч шийдвэрлэхийг мэдэгдсэнээр гэр хорооллын зарим хэрэглэгчдийн цахилгаан дамжуулах шугамыг бүрээстэй утсаар солих, дэд өртөөний трансформаторын хүчин чадлыг нэмэх зэрэг арга хэмжээг авч байгаа боловч өсөн нэмэгдэх хэрэглээнээс шалтгаалан томоохон өөрчлөлт хийх шаардлага үүсч байна.
- Өр төлбөрийн маргаанууд ихэнх хувийг эзэлж байна.

Дулааны эрчим хүчтэй холбоотой гомдлуудын хувьд:


Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу бичгээр хандсан 153 хэрэглэгчээс гадна дараах хэлбэрүүдээр дулааны эрчим хүчний хэрэглэгчдээс гомдол маргааныг хүлээн авч шийдвэрлэн, шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж, зөвлөмж зөвлөгөө өгч ажилласан. Үүнд:



Албан бичгээр ирсэн өргөдөл, гомдол

33% | 50

Чанар хангамж, халаалт, халуун ус доголдсон, орон сууцны ашиглалтыг өөр тусгай зөвшөөрөл эзэмшигчээр хариуцуулах, СӨХ-ны үйл ажиллагааг давхар эрхэлж байгаа асуудлуудаар



6% | 9

Хэмжих хэрэгсэл, дулааны төлбөрийг дулааны тоолуураар тооцуулахыг хамарсан асуудлууд

61% | 94

Төлбөр тооцоо буюу дутуу нийлүүлсэн дулааны төлбөр хасуулах, илүү төлбөр нэхэмжилсэн, өр төлбөрийн асуудлаар дүгнэлт гаргуулах

Дулааны эрчим хүчтэй холбоотойгоор Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хэрэглэгчийн 11 гомдол, хүсэлтийн дагуу төлбөрийн тооцооллыг шалгаж холбогдох төлбөрийн хасалт, төлөлтийг хийлгүүлсэн байна. Үүнд:

"УБДС" ТӨХК, "Астра", Женерал" СӨХ, иргэн Ганбаатар, "Ган инженеринг" ХХК, "Хүрээ хаус" ХХК, Иргэн Одсүрэн, "Ач-Очир" ХХК-д холбогдох 406.594.659 төгрөгийн төлбөрийн төлөлт, "Шунхлай" СӨХ, "Ханан" СӨХ, Иргэн Батдорж, "Реженси резиденци" СӨХ, "Гурван билэг" ХХК нарт холбогдох 36.283.196 төгрөгийн төлбөрийг буцаан төлүүлж ажиллалаа.

Мөн дулааны эрчим хүчтэй холбоотой "Астра" СӨХ, "Шунхлай" СӨХ, "Хорин дөрвөн цаг" ХХК, "Анд интернэйшнл" ХХК, "Газар шилтгээн" ХХК, Иргэн Сүрэндулам, Иргэн Амарсайхан, "Ханан СӨХ, ХҮТ-1, ХҮТ-2, ТОДББ ХХК, "Актив партнерс" ХХК, "Сайн хөрш" СӨХ зэрэг холбогдох 10 хэрэглэгчийн өргөдөл, 2 иргэний өргөдлийн дагуу нийт 12 өргөдөл гомдлын дагуу газар дээр нь ажиллаж шийдвэрлэсэн байна.

Дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөлтэй хувийн хэвшлийн 66, Орон

нутгийн төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа 10 тусгай зөвшөөрөл эзэмшигч, "ОСНААУГ" ОНӨААТҮГ, "УБДС" ТӨХК зэрэг нийт 79 компанийн "Хэрэглэгчийн эрх ашгийг хангах"-тай холбоотой нөхцөл шаардлагыг дүгнэж ажилласан.

Дулааны эрчим хүчтэй холбоотой дараах нийтлэг зөрчил дутагдлууд гарч байна.

- СӨХ болон хэрэглэгчдээс тусгай зөвшөөрөл эзэмшигч /ТЗЭ/ хувийн компаниудын тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээнээс орон сууцны ашиглалт үйлчилгээг хасуулах, ашиглалтыг Орон нутгийн өмчит тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлж хариуцуулах,
- СӨХ, ТЗЭ хоорондын дундын өмчлөлийн халаалтын өр төлбөрийн маргаан
- Хэрэглэгчээс стандартын шаардлага хангасан эрчим хүчээр хангагдахгүй байгаа буюу хангагч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй эрчим хүч дутуу нийлүүлсэн асуудлаар ихэнх гомдлууд гарч байна.

“ДУЛААН ОРЧИН-ХЭРЭГЛЭГЧИЙН АЯ ТУХ” АЯН

Эрчим хүчний зохицуулах хорооны даргын баталсан “ДУЛААН ОРЧИН-ХЭРЭГЛЭГЧИЙН АЯ ТУХ-2020” сэдэвт аяны удирдамж, төлөвлөгөөний дагуу халаалтын улиралд хэрэглэгчдийг ая тухтай өвөлжих нөхцөлийг бүрдүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор 3 дахь жилдээ зохион байгуулж ажиллалаа.

Уг аяны хүрээнд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч хувийн хэвшлийн 66 компани, орон нутгийн өмчит 1 компанийн нийт 67 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 190 гаруй ажилтан, албан хаагчдыг хамруулсан чадваржуулах сургалтыг 2020 оны 01 дүгээр сарын 13, 15-ны өдрүүдэд зохион байгуулсан. Энэ сургалтыг дараах сэдвүүдээр зохион байгуулав. Үүнд;

- Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтийн тайлан бэлдэх, түүнийг дүгнэх;
- Төлбөрийн мөнгөний урсгалын хувь хэмжээг тогтоох, үнэ тарифын санал боловсруулах;
- Аж ахуйн харилцааны дүрмийг хэрэгжүүлэх, хэрэглэгчийн өргөдөл гомдлын шийдвэрлэх, цаашид авах арга хэмжээ;
- “Холболтын журам”-ын нэмэлт өөрчлөлт;
- Эрчим хүчний хэмнэлтийн бодлого, эрчим хүч хэмнэлт, зохистой хэрэглээ.

Аяны төлөвлөгөөний дагуу Хорооны холбогдох мэргэжилтнүүд Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа орон сууц ашиглалтын дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч хувийн хэвшлийн орон сууцны 15 компани /Хороонд хэрэглэгчийн гомдол, санал ихээр ирүүлдэг 10 хуулийн этгээд, 2019 оны сүүлээр шинээр тусгай зөвшөөрөл авсан 5 хуулийн этгээд/, ОСНААУГ-ын харъяа орон нутгийн өмчит 3 түгээх төв, хэрэглэгчдэд үйлчлэх төвийн үйл ажиллагаанд шалгалт хийхээр төлөвлөж, 7 ТЗЭ-ийн үйл ажиллагааг газар дээр нь шалгав.

Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүд тухайн орон нутагтаа “Дулаан орчин-Хэрэглэгчийн ая тух 2020” аяныг Зохицуулах зөвлөлийн даргын тушаалаар төлөвлөгөө батлан, зохион байгуулж тухайн аймгийн Засаг дарга, аймаг, нийслэлийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд хэрэглэгчийн аяныг хамтран хэрэгжүүлэх талаар мэдэгдэж, үүрэг даалгавар чиглэлийг өгч хамтарч ажилласан байна.

АНЗЗ-үүд нь орон нутагт хэрэглэгчийн аяныг хэрэгжүүлж ажилласнаар ТЗЭ-дийн дулаан түгээх, хангах үйл ажиллагааг хэвийн явуулж, сумдын усан халаалтын зуух, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудын нүүрс татан авалт, дулаан хангамжийн үйл ажиллагаанд ямар нэгэн ноцтой зөрчил дутагдал, гэмтэл сааталгүй, хэрэглэгчдийг халаалтын улиралд ая тухтай өвөлжих нөхцөлийг хангуулав.

Аяны хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлтийг гарган тусгай зөвшөөрөл эзэмшигч нарт хүргүүлж ажиллав. Үүнд;

1. Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүд аяны хүрээнд хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ, сумдын Засаг дарга болон тусгай зөвшөөрөл эзэмшигч нараас ирүүлсэн тайлан мэдээг нэгтгэх, цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх санал дүгнэлтийг гарган ирүүлэх;
2. Дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаа, техник технологи, боловсон хүчний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, харилцаа, ёс зүйд анхаарах, ТАД, ААД, ХАБЭА-н дүрэм журмуудыг мөрдөж ажиллах, ажилчдыг мэдээллээр хангах;
3. Хорооны тогтоолоор баталсан дүрэм, журмыг мөрдөж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг бүрэн биелүүлж ажиллах, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын тайланг тогтоосон хугацаандаа ирүүлэх;
4. Өвөлжилтийн бэлтгэл ажил, урсгал засварын ажлыг бодитоор төлөвлөж хэрэгжүүлэх, засварын төлөвлөгөө биелэлтийг нэгтгэн гаргах, халаалт, халаалтын шугамын нягтын шахалт хийж, шахалтын акт, бичиг баримтыг бүрдүүлэх;
5. 2 дугаар хэлхээний горим тохируулга, гидравлик тооцоог боловсруулж хангагч байгууллагаар хянуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах, анхан шатны бичиг баримтыг хөтөлж хэвших, бүртгэлийг сайжруулах;
6. Хэрэглэгчийн дуудлагын нэгдсэн диспетчерийн үйл ажиллагаатай болох, дуудлага барагдуулалтын судалгаа, тайлан мэдээ гаргаж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг жилд нэг удаа авч ажиллах, олон нийтэд үйл ажиллагаагаа сурталчлах, мэдээллэх.

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зохицуулах зөвлөлүүд нь 2019 онд 265 тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын үйл ажиллагааг зохицуулан, Эрчим хүчний зохицуулах хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу ажилласан бол 2020 онд зохицуулах зөвлөлүүд 85 хуулийн этгээдэд 120 тусгай зөвшөөрлийг шинээр олгож, 95 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 12 тусгай

зөвшөөрлийг хүчингүй болгосноор 296 тусгай зөвшөөрөл эзэмшигчид дулаан үйлдвэрлэх, түгээх, дулаанаар зохицуулалттай хангах, эрчим хүчний барилга байгууламж барих, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 6. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо

№	АНЗЗ	ТЗЭ-ийн тоо (2020 оны жилийн эцэс)	Тусгай зөвшөөрлийн төрөл					Нийт
			Үйлд- вэрлэх	Түгээх	Зох. Хангах	ЭХББ Барих	ЦЭХ	
1	Архангай	11	10	10	11	-	-	31
2	Баян-Өлгий	13	15	15	15	1	-	46
3	Баянхонгор	28	27	27	27	9	-	90
4	Булган	6	6	6	6	-	-	18
5	Говь-Алтай	11	9	9	9	1	1	29
6	Говьсүмбэр	4	4	4	4	-	-	12
7	Дархан-Уул	5	5	5	5	-	-	15
8	Дорноговь	3	3	3	3	-	-	9
9	Дорнод	9	12	0	0	-	4	16
10	Дундговь	6	6	6	6	-	-	18
11	Завхан	23	23	22	22	1	-	68
12	Орхон	2	1	2	2	-	-	5
13	Өвөрхангай	32	32	32	32	-	-	96
14	Өмнөговь	23	25	19	22	2	-	68
15	Сүхбаатар	7	7	7	7	-	-	21
16	Сэлэнгэ	15	15	15	15	-	-	45
17	Төв	11	15	15	15	-	-	45
18	Увс	22	22	22	22	-	-	66
19	Ховд	14	8	7	7	7	1	30
20	Хөвсгөл	12	12	12	12	-	-	36
21	Хэнтий	18	18	17	18	-	-	53
22	Нийслэл	21	21	9	9	-	-	39
Нийт		296	296	264	269	21	6	856

21 аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөл болон Нийслэлийн зохицуулах зөвлөл нь Эрчим хүчний тухай хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу 2020 онд дулаан үйлдвэрлэх 296, дулаан түгээх 264, дулааны эрчим хүчээр зохицуулалттай хангах 269, цахилгаан үйлдвэрлэх 6, эрчим хүчний барилга байгууламж барих 21 тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий 29 тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран ажилласан.

Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл нь 2019 онд 135 удаа хуралдаж 335 тогтоол шийдвэрийг гаргаж байсан бол 2020 онд 132 удаа хуралдаж 298 асуудлыг шийдвэрлэн ажиллажээ. ТЗЭ-дийн тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах 88 тогтоол, хэрэглэгчдэд борлуулах дулааны тариф болон хэрэгцээний халуун ус халаасны үнэ тариф тогтоох 88 асуудал, зохицуулах зөвлөлийн дотоод үйл ажиллагааг зохицуулах 70 асуудал, үнэ тарифын харилцааг зохицуулах 52 асуудал, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтийг хянах болон хяналт, шалгалтын дүн шинжилгээг танилцуулах 43 асуудал нийт 298 асуудлыг шийдвэрлэн ажиллажээ.

АНЗЗ-үүд нь Эрчим хүчний тухай хуулиар олгогдсон эрх үүргийн хүрээнд 2020 онд 48 аж ахуй нэгжид дулаан үйлдвэрлэх, түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийг шинээр олгож, 33 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хугацааг сунган, 4 ТЗЭ-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Аймаг нийслэлийн зохицуулах зөвлөлүүдээс 14 аймгийн зохицуулах зөвлөл 85 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг шинээр болон өөрчлөлт оруулан батлан мөрдүүлж байна.

Мөн 2020 онд зохицуулах зөвлөлүүд Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 274 дүгээр тогтоолоор баталсан “Эрчим хүчний хэмнэлтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.13-т зааснаар тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс хэмжүүрээр тооцох дулааны тарифыг боловсруулах ажлыг эхлүүлсэн ба Эрчим хүчний зохицуулах хорооны даргын 2018 оны А/119 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдан хэмжүүрийн тариф боловсруулахад зохицуулах зөвлөл-орон тооны гишүүдэд мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилласан юм. Засгийн газрын 144 дүгээр тогтоол гарсантай холбогдуулан төсөвт болон орон нутгийн өмчит байгууллагуудыг тоолууржуулах ажлын хүрээнд АНЗЗ-үүд ч мөн төсөвт байгууллагуудын мөрдөх хэмжүүрээр тооцох дулааны тарифыг

Хүснэгт 7.

№	АНЗЗ	ТЗЭ-ийн тоо		
		ТЗ олгосон	ТЗ сунгасан	ТЗ хүчингүй болгосон
1	Архангай	1	-	-
2	Баян-Өлгий	5	-	-
3	Баянхонгор	2	-	-
4	Булган	-	4	-
5	Говь-Алтай	3	3	-
6	Говьсүмбэр	-	1	-
7	Дархан-Уул	1	-	-
8	Дорноговь	1	-	-
9	Дорнод	4	3	-
10	Дундговь	1	2	-
11	Завхан	4	12	-
12	Орхон	1	-	-
13	Өвөрхангай	3	3	3
14	Өмнөговь	2	-	-
15	Сүхбаатар	-	-	-
16	Сэлэнгэ	-	-	-
17	Төв	1	1	1
18	Увс	-	1	-
19	Ховд	9	-	-
20	Хөвсгөл	3	-	-
21	Хэнтий	7	-	-
22	Нийслэл	-	3	-
Нийт		48	33	4

батлах шаардлагатай болсон. Энэ ажлын хүрээнд 2020 оны 09 дүгээр сард орон тооны гишүүдэд “Дулааны тоолуур, түүнийг суурилуулах үеийн анхаарах асуудлууд” сэдэвт сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулсан. 2020 онд 9 аймгийн зохицуулах зөвлөлөөс 44 ТЗЭ-ийн хэмжүүрийн тарифын саналыг авч, тооцооллыг хянасан байна.

Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүд 2020 онд нийт 704 албан бичиг хүлээн авч, 69 хэрэглэгчийн өргөдөл гомдол болон 485 хариутай албан бичгийг шийдвэрлэн ажилласан байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 100 хувьтай байгаа ба зохицуулах зөвлөлүүд ирсэн өргөдөл, гомдлын мэдээллийг Эрчим хүчний зохицуулах хорооны цахим мэдээллийн сайтад сар бүр бүртгэн ажиллаж байна.

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛҮҮДИЙГ МЭРГЭЖИЛ, АРГАЗҮЙН УДИРДЛАГААР ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛУУД

Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл (АНЗЗ)-үүд нь 2020 онд 19 хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгосноор орон нутагт нийт 296 тусгай зөвшөөрөл эзэмшигч компани Монгол Улсын хэмжээнд 225 суманд дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах үйл ажиллагааг эрхэлж байна. Эрчим хүчний зохицуулах хорооноос АНЗЗ-үүдийг мэргэжил, аргазүйн удирдлагаар хангах чиг үүргийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ. Үүнд:



- Нийслэл хот болон 21 аймгийн зохицуулах зөвлөлүүдээс олгосон дулаан үйлдвэрлэх, түгээх, дулаанаар зохицуулалттай хангах нийт 238 тусгай зөвшөөрөл эзэмшигч, тэдгээрээс дулааны эрчим хүчээр хангагдаж буй хэрэглэгчдийн дагаж мөрдөх, дулааны хэмжүүрийн тарифын суурь тооцооллыг Эрчим хүчний зохицуулах хорооны баталсан "Цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ тарифыг тогтоох аргачлал"-ын дагуу хэрхэн тооцоолох, үнэ тарифын санал хянах аргачлалыг зөвлөлүүдийн орон тооны гишүүдэд зааж сургах ажлыг хэрэгжүүллээ.
- АНЗЗ-үүд нь Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь заалтад заасны дагуу 3 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа бөгөөд 2020 онд Аймаг, орон нутгийн сонгуультай холбоотойгоор 21 аймгийн зохицуулах зөвлөлийн дарга бөгөөд орон тооны бус гишүүдийг чөлөөлж, 18 аймгийн

зохицуулах зөвлөлийн дарга бөгөөд орон тооны бус гишүүдийг аймгийн Засаг дарга нартай зөвшилцөн дахин томилоод байна. Мөн 4 аймгийн зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүнийг томилох, чөлөөлөх асуудлыг Хорооны хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн.

- Зохицуулах зөвлөлүүдийн 2019 оны жилийн үйл ажиллагааны тайланг авч нэгтгэн "Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүний ажлыг дүгнэх журам"-ын дагуу тэдгээрийн үйл ажиллагааг дүгнэв. Мөн 2020 оны зардлын төсвийн саналыг хянаж, Хорооны хурлаар хэлэлцэн зохицуулах зөвлөлүүдэд зөвлөмж хүргүүлсэн.
- Орон нутгийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтийг дүгнэх, үнэ тарифын харилцааг зохицуулах асуудлаар болон эрчим хүчний хэмнэлт, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр сар бүр заавар зөвлөгөөг өгч ажиллалаа.

АНЗЗ-үүд нь 2020 онд нийт 132 удаа хуралдаж, тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгохтой холбоотой 88 асуудал, үнэ тариф батлах 43 асуудал, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлт дүгнэх 52 асуудал, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт, шалгалт хийсэн дүнтэй холбоотой 45 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна. АНЗЗ-үүд нь нийт 704 албан бичгийг хүлээн авч, хариутай 485 албан бичгийг шийдвэрлэн ажилласан байна.

АНЗЗ-үүд нь 2020 онд 76 тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үнэ тарифын саналыг хүлээн авч, тэдгээрийн үйлчлэх хүрээнд хамаарах хэрэглэгчдэд борлуулах үнийг баталж, мөрдүүлсэн байна. Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн дагуу Засгийн газрын 2019 оны 144 дүгээр тогтоол батлагдсантай холбогдуулан аймаг, орон нутгийн төсөвт байгууллагуудыг тоолууржуулах ажлын хүрээнд АНЗЗ-үүд нь 2020 онд 44 тусгай зөвшөөрөл эзэмшигчээс хэмжүүрээр тооцох дулааны тарифын саналыг хүлээн авч хянаж, тарифыг батлан хэрэглэгчдэд мөрдүүлэн ажиллаж байна.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ, ҮР АШИГ

Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр (ЭХХҮХ), эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд:

Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар, байгууллага хоорондын уялдааг хангах, хамтран ажиллах хүрээнд СЯ, БХБЯ, БОАЖЯ, ЗТХЯ, УУХҮЯ, ХХААХҮЯ, БСШУЯ, НЗДТГ болон Олон улсын байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэх, тэдгээр байгууллагатай хамтран ажиллаж Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд туссан 11 зорилт, 49 ажил, арга хэмжээг ЭХЗХ-ны 2020 оны зорилт, ажлын төлөвлөгөө болон Эрчим хүчний сайдын 2018 оны 89 дүгээр тушаалаар байгуулсан Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийн нарийвчилсан төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэв. Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх нэгдсэн тайланг боловсруулж ЗГХЭГ, ЭХЯ-нд хүргүүлж ажилласан ба Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд ЭХЯ-аас хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Үндэсний хөтөлбөрийн 2019 оны хэрэгжилтийг 92.2%-ийн биелэлттэй гэж дүгнэсэн бөгөөд тайланг Эрчим хүчний сайдын 2020 оны 03 сарын 09-ний өдрийн а/810 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж Засгийн газарт тайлагнасан болно. ЭХХҮХ-ийн 2020 оны хэрэгжилт 93%-ийн гүйцэтгэлтэй дүгнэгдэж байгаа ба 2021 оны 1-р улиралд багтаан Засгийн газарт тайлагнахаар ажиллаж байна.

Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх талаар аймаг, нийслэлийн Засаг дарга, харьяа нэгж, Аймгийн зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүдийг мэдээлэл, зөвлөмжөөр ханган ажиллав. Орон нутагт хэрэгжүүлсэн эрчим хүч хэмнэлтийн талаарх тайлан мэдээллийг нэгтгэн цахим системд байршуулсан болно.

Аймаг, нийслэлийг хөгжүүлэх үндсэн чиглэлд орон нутгийн дэд хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тусгаж хэрэгжүүлэх талаар ЭХЗХ-ноос албан бичгээр 21 аймгийн Засаг дарга нарт

зөвлөмж, мэдээлэл хүргүүлэн ажиллав. Мөн Эрчим хүчний сайд, аймгийн Засаг дарга нартай байгуулсан 2019 оны хамтран ажиллах гэрээний "Орон нутгийн онцлогт тохирсон Эрчим хүч хэмнэлтийн бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх" гэсэн заалтын хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж ЭХЯ-д хүргүүлсэн.



Орон нутагт эрчим хүчний хэмнэлтийг хариуцан ажиллаж буй холбогдох мэргэжилтнүүдийг чадавхжуулах, мэдээллээр хангах зорилгоор ЭХЯ, СХЗГ, "УБДС" ТӨХК, ШУТИС ЭХС, ТХААГ-тай хамтран АНЗЗ болон 21 аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлт, дэд бүтэц хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан сургалтыг 2020.09.11-12-ны өдрүүдэд зохион байгуулсан.



Сургалтад 18 аймгийн зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн, 13 аймгийн ЗДТГ-ын мэргэжилтэн хамрагдсан.

Эрчим хүч хэмнэлтийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, сайжруулах ажлын хүрээнд:

Эрчим хэмнэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, зөвлөмж, Эрчим хүчний зохицуулах хорооны хөгжлийн стратеги төлөвлөгөөнд Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх, эрх зүйн орчныг сайжруулах санал боловсруулах гэж заасныг тус тус үндэслэн Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, эрх зүйн баримт бичгийг сайжруулах санал боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулав. Тус судалгааны ажлыг Даян дэлхийн ногоон хөгжлийн институтын (ДДНХИ)-ийн дэмжлэгээр “Монгол өмгөөлөл” хууль зүйн фирм ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох зүйл, заалт, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу судалгааны ажлыг гүйцэтгэж Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварыг үнэлсэн. Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн санал боловсруулсан. Мөн дагалдах бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулах, үүнтэй уялдуулан бусад эрх зүйн баримт бичгийг сайжруулах санал, зардлын тооцоог хийж гүйцэтгэсэн.

Эрчим хүчээр ажилладаг машин, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний цахилгаан бараанд эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журмыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд:

Олон улсын норм, стандартыг судлан Олон улсын цахилгаан техникийн хорооны зарим стандартуудыг үндэсний болгох бэлтгэл ханган ажиллав. Үүнд; Ахуйн хэрэглээний зориулалттай хөргөгч хөлдөөгч, угаалгын машин, цахилгаан зуух буюу плитка, тэдгээрийн үр ашгийн үзүүлэлт, туршилт хийх аргууд IEC 62552-3:2015, IEC 60456:2010, IEC 60350-1; зэрэг болно. Мөн түүнчлэн журмын төсөлд тусгагдсан

Эрчим хүчний үр ашгийн шошгын хэлбэр хэмжээний стандартын төслийг ЭХЭЗХ-ийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж холбогдох санал, зөвлөмжийг тусган боловсруулсан. Эрчим хүчээр ажилладаг машин, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний цахилгаан барааны эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах” журмын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх хүсэлтийг ЭХЭЗХ-ны даргын 2020.11.02-ны өдрийн 1/1342 тоот албан бичгээр Эрчим хүчний сайдад хүргүүлсэн. Журмын төсөлд санал авахаар Эрчим хүчний сайдын 2020.12.07-ны өдрийн а/4016 дугаартай албан бичгийг холбогдох төрийн байгууллага, бүх яамдад хүргүүлэн саналыг тусган нэгтгэж ЗГХЭГ-т хүргүүлэх бэлтгэл хангагдав.

Барилга байгууламжийн эрчим хүчний хэрэглээний үр ашгийг дээшлүүлэх, нормативын баримт бичгийг сайжруулах хүрээнд:

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагуудыг тоолууржуулах суурь судалгааг 2020 онд хийж гүйцэтгэн Засгийн газрын 2020 оны 04 сарын 22-ний өдрийн 144 дүгээр тогтоолыг батлуулав. Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг Эрчим хүчний сайдын 2020 оны 11 дүгээр тушаалаар батлуулан холбогдох ажлыг зохион байгуулан ажиллав. Энэ ажлын үр дүнд төсөвт байгууллагын барилгын эрчим хүчний хэрэглээний үр ашгийг сайжруулах, хэрэглээг бодитоор хэмжиж тооцдог байх зарчимд шилжих суурь нөхцөл хангагдав.

Барилга, хот байгуулалтын яамтай хамтран Барилгын дулаан хамгаалалтын нормыг шинэчлэх ажлыг зохион байгуулав. Энэхүү норм нь анх 1998 онд батлагдаж, 2009 шинэчлэгдэж байсан бөгөөд норм шинэчлэгдсэнээр барилгыг эрчим хүчний хэмнэлттэй төлөвлөх, гүйцэтгэх, мөн одоо байгаа барилга байгууламжийг эрчим хүчний хэрэглээгээр нь гэрчилгээжүүлэх суурь нөхцөл хангагдсан. Барилга байгууламжид эрчим хүчний хэрэглээний гэрчилгээ олгох журмын төслийг боловсруулах ажлын хэсгийг БХБ-ын сайдын тушаалаар байгуулан ажиллаж байгаа бөгөөд ажлын хэсгийн гишүүдийн саналыг тусган журмын төслийг эцэслэн боловсруулж Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлээд байна. Түүнчлэн EN834 Халаах хэрэгслийн зардал хуваарилагч – Аллокаторын ерөнхий шаардлага стандартыг зохих журмын дагуу хэлэлцүүлж үндэсний стандартаар батлуулав.

Эрчим хүчний менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд:

Эрчим хүчний менежментийн тогтолцооны MNS ISO50001:2018 стандартыг нутагшуулах стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг ЭХЗХ, Эрчим хүчний яам, Стандарт, хэмжил зүйн газар болон стандартын зөвлөх байгууллагын төлөөллөөс бүрдүүлж ЭХЗХ-ны даргын А/156 тоот тушаалаар байгуулсан. Ажлын хэсгээс "Эрчим хүчний менежментийн тогтолцоо MNS ISO 50001:2018 стандартыг Монгол улсад нутагшуулах стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулсан ба ISO 50001 Эрчим хүчний менежментийн тогтолцооны стандартыг нутагшуулах хүний нөөцийг бэлтгэх зорилгын хүрээнд Стандарт, хэмжил зүйн газар болон Германы физик техникийн хүрээлэнгийн "Эрчим хүчний салбарын чанарын удирдлагыг сайжруулах" төсөлтэй хамтран ISO 50001, 50002, 50003, 50006, 50015, 50047, EN 16247:1-5, ISO 19011, 17021-1 стандартын онлайн сургалтыг зохион байгуулж олон улсын эрхтэй дотоод аудиторудыг бэлтгэн гаргав. Мөн түүнчлэн тус стандартын ач холбогдлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах зорилгоор холбогдох сургалт, уулзалтуудыг зохион байгуулж Эрчим хүч хэмнэлтийн менежер, аудиторын шинэчилсэн сургалтын хөтөлбөрт Эрчим хүчний удирдлагын тогтолцооны ISO стандартын талаарх хичээлийг тусган зааж байна.



Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн "Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд:

Эрчим хүч хэмнэх Үүрэг хүлээсэн 129 хэрэглэгчийн 2019 оны үйл ажиллагааг Хорооны 2019 оны 419 дүгээр тогтоолоор баталсан аргачлалын дагуу үнэлэн Хорооны хурлаар хэлэлцэж үнэлгээний дүгнэлтийг ЭХЗХ-ны 2020 оны 04 дүгээр сарын 17-ын 233 дугаар тогтоолоор баталсан. Хангалтгүй үнэлгээтэй дүгнэгдсэн 44 үүрэг хүлээсэн хэрэглэгчдэд Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, эдгээрээс 22 ҮХХ-ийн газар дээр нь очиж үйл ажиллагаатай танилцан хэрэгжилтийг хангуулах талаар зөвлөмж чиглэл өгсөн. Мөн дунд үнэлгээ авсан үүрэг хүлээсэн хэрэглэгчдэд эрчим хүчний хэмнэлтийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлийг албан тоотоор хүргүүлж, гүйцэтгэлд хяналт тавин ажиллав. Үүрэг хүлээсэн хэрэглэгч бүрт хүрч ажиллах удирдамж, төлөвлөгөөг Эрчим хүчний зохицуулах хорооны даргаар батлуулж нийт 22 хэрэглэгчийн төлөөлөлтэй биечлэн уулзаж, 15 хэрэглэгчтэй цахим уулзалт зохион байгуулж хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар зөвлөмж чиглэл өгч ажиллав. Холбогдох журмын хүрээнд 2020 онд үүрэг хүлээсэн хэрэглэгчээс хасуулах хүсэлт ирүүлсэн байгууллагуудын материалыг судалж Хорооны 2020 оны 09 сарын 17-ны өдрийн хурлаар хэлэлцэж 449 дүгээр тогтоолоор бүртгэлээс хасав.



Хүснэгт 8. Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээний мэдээлэл, үйл ажиллагааны чиглэл тус бүрээр

Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн ангилал	Цахилгаан /сая кВт.ц/			Дулаан /мян.Гкал/жил/		
	2018	2019	2020	2018	2019	2020
Улсын болон орон нутгийн өмчит байгууллага	123.3	45.5	40.3	96.4	113.5	160.2
Бусад аж ахуйн нэгж байгууллага	84.8	68.8	57.8	43.5	45.4	85.8
Нийт Барилга байгууламж ангилал	208.1	114.3	98.1	140.0	158.9	246.0
Хөнгөн, хүнсний үйлдвэр	100.3	159.5	130.4	164.3	251.5	262.3
Хүнд үйлдвэр	200.8	267.1	207.4	16.5	31.8	35.3
Үйлчилгээ	90.1	171.4	173.2	18.8	22.0	40.9
Уул уурхай	2668.8	2791.6	2793.7	42.9	605.8	632.9
Нийт Эрчим хүч хэрэглэгч ангилал	3060.0	3389.6	3304.8	242.6	910.8	971.4

График 19. Цахилгаан эрчим хүчний хэрэглээ, сая кВт.ц**График 20. Дулааны эрчим хүчний хэрэглээ, Мян.Гкал/жил**

Мөн Хорооны Дотоод аудитын газартай хамтран Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хэмнэх үйл ажиллагаанд аудит хийх ажлын хүрээнд үүрэг хүлээсэн 3 хэрэглэгчийн эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай нь газар дээр нь танилцаж мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулсан. Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн хуулийн хэрэгжилтийг үнэлэх, дотоод аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох ажлыг зохион байгуулан ажиллав.

Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах Тусгай зөвшөөрөл эзэмшигч нийт 124 компанийн 2019 оны нөхцөл шаардлагын зорилтын Эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлыг дүгнэн, 2020 оны зорилтыг тогтоов. Тогтоосон зорилтын хэрэгжилтэд жилийн турш хяналт тавьж ажиллалаа.

Эрчим хүчний хэмнэлтийн менежер бэлтгэх сургалтын дараа тухайн сургалтын чанарыг

үнэлэх судалгааг тогтмол явуулж байгаа бөгөөд судалгааны үр дүнд үндэслэн ҮХХ-дэд эрчим хүчний аудит, хэмнэлт, үр ашгийн талаар цогц мэдээлэл өгөх, менежерүүдийн сургалтаар олж авсан мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилготой нийт 9 сэдэв бүхий 18 цагийн видео хичээл, танилцуулга, мэдлэг шалгах тестийг сургагч багш нартай хамтран боловсруулж 2020 оны 06 дугаар сард цахим сургалт зохион байгуулсан. Тус сургалтад нийт 137 ажилтан хамрагдсан болно.

Эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежерийг бэлтгэж мэргэшүүлэн, мэргэжлийн байгууллагыг магадлан итгэмжлэх хүрээнд:

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.8-д заасны дагуу эрчим хүч хэмнэлтийн менежерийг бэлтгэх, мэргэжлүүлэх сургалтыг зохион

байгуулан ажиллав. Эрчим хүчний аудитор, менежер бэлтгэх сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, сайжруулах санал, зөвлөмж боловсруулах Ажлын хэсгийг ЭХЗХ-ны даргын 2020 оны А/29 дугаар тушаалаар байгуулан ажилласан бөгөөд Эрчим хүчний аудитор, хэмнэлтийн менежер бэлтгэх сургалтын хөтөлбөр"-ийг ЭХЗХ-ны 2020 оны 470-р тогтоолоор шинэчлэн батлав.

Эрчим хүчний аудиторын давтан сургалт болон эрх сунгах ажлын хүрээнд аудиторуудын давтан сургалт, тайлан хамгаалалт, шалгах авах ажлыг зохион байгуулж ЭХЗХ-ны 2020.04.30-ны өдрийн 286-р тогтоолоор эрчим хүчний 16 аудиторын эрхийг сунгаж баталгаажуулсан. Мөн 2020 оны 12-р сард эрхийн хугацаа нь дууссан барилгын эрчим хүчний 18 аудиторын эрх сунгахтай холбоотой ажлыг баталсан удирдамжийн дагуу зохион байгуулж Хорооны хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн.

Эрчим хүч хэмнэлтийн менежерийн сургалтад 2019 оны 12-р сард хамрагдсан ҮХХ-ийн менежерүүдээс шалгалт авах ажлыг 2020.1.13-ны өдөр зохион байгуулж шалгалтад тэнцсэн 41 эрчим хүчний хэмнэлтийн менежерт эрх олгов. 2020 онд Эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх сургалтыг зохион байгуулсан бөгөөд сургалтад 23 суралцагч хамрагдсан.

Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолоор баталсан Эрчим хүчний аудитын болон эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын эрх олгох, магадлан итгэмжлэх журмын дагуу "Дулаан техникийн шинэчлэлийн төв" ХХК, "Зэт энерго сервис" ХХК-дад аудитын магадлан итгэмжлэлийг шинээр олгож, "Элчит эрчим хүч ХХК", "Цог зориг" ХХК, "Киловатт цаг" ХХК- дад олгосон эрчим хүчний аудитын магадлан итгэмжлэлийн хугацааг тус тус сунгах асуудлыг Хорооны хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн. Мөн "Монхорус интернэшнл" ХХК-д эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын магадлан итгэмжлэл олгох асуудлыг Хорооны хурлаар шийдвэрлэж Эрчим хүчний аудитын 14, ЭСКо 2 байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж хамтран ажиллав.

Барилгын эрчим хүчний аудиторуудыг чадавхжуулах зорилгоор Барилгын дулаан хамгаалалтын нормыг танилцуулах, барилгын эрчим хүчний гэрчилгээ боловсруулах сэдэвт сургалтыг 2020 оны 11-р сард зохион байгуулж 28 аудиторыг хамрууллаа.

2021 оны 1-р сарын байдлаар 64 аудитор аудитын үйлчилгээний зах зээл дээр ажиллаж байгаагаас 15 аудитор бие даан, 49 аудитор 14 магадлан итгэмжлэгдсэн аудитын байгууллагад харьяалагдан ажиллаж байна.

График 21. Эрчим хүчний аудиторууд





График 22. Аудиторуудын ажлын туршлага



2021 оны 1-р сарын байдлаар 11 удаагийн сургалтаар нийт 241 Эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэсэн бөгөөд үүнээс 22,4% сайн дурын үндсэн дээр, түүнчлэн нэг байгууллагаас олон ажилтан суралцсан байна.

График 23. ЭХХМ-ын суралцсан байдал





График 24. ЭХХМ-ын ажлын байр

15.4%

ЭХХМ-ийн бие даасан ажлын байр



Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, ач холбогдлыг сурталчлах, олон нийтэд таниулах хүрээнд:

Ерөнхий боловсролын сургуулиудын бага ангийн сургалтын агуулгад Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийг тусгуулах саналыг боловсруулж албан бичгээр БСШУС-ын сайдад хүргүүлсэн бөгөөд хөтөлбөрийг шинэчлэх ажлын хэсгийг байгуулж, удирдамжийг ЭХЗХ, Нийслэлийн боловсролын газрын даргаар батлуулан ажиллаж байгаа ба 2020 онд сурагчдад зориулсан эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийг цахимаар түгээх ажлыг зохион байгуулав.

Мөн Нийслэлийн Засаг даргын 2020.01.16-ны А/27 тоот захирамжаар батлагдсан "Хотын соёл" мэдээллийн цаг арга хэмжээний 1-4 дүгээр ангийн "Хэрэглээний соёл" сэдвийн агуулгад эрчим хүчний хэмнэлт, хэрэглээний талаар тусгуулж, сурагчдад эрчим хүчийг зохистой хэрэглэх, хэмнэх тухай таниулах, дадал эзэмшүүлэх мэдээллийг түгээх боломжийг бүрдүүлээд байна. Түүнчлэн Нийслэлийн ерөнхий боловсролын 47 сургууль, Дорнод аймгийн 12 сургуулийн Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийг заасан тухай ажлын тайлантай танилцаж, хичээлийн чанар хүртээмж, агуулга, арга зүйг судлан, давуу ба сул талуудыг тодорхойлон үнэлж хөтөлбөрийг сайжруулж ЭХЗХ, Нийслэлийн боловсролын газрын даргаар батлуулсан. Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 33 сургагч багшийг чадавхжуулах сургалтыг 2020.11.06-ны өдөр зохион байгуулсан.

Эрчим хүч хэмнэлтийн үр өгөөжийг сурталчилсан, Хорооны оффисын танилцуулгын өрөөний засал, тохижилтын ажилд шаардлагатай 45 сая төгрөгийн санхүүжилтийг ГОУХАН-ийн төслөөс шийдвэрлүүлж хэрэгжүүлэв.

Барилгын эрчим хүчний гэрчилгээ гэж юу вэ сэдвээр олон нийтэд зориулсан шторкийг ДДНХИ-ын дэмжлэгээр гүйцэтгэн, олон нийтэд түгээж эхлээд байна.

https://youtu.be/2L_gt4tFZps




Монгол Улсын Засгийн газраас Ковид-19 цар тахлыг даван туулах, түүний нийгэм, эдийн засагт учруулж буй сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор 2020 оны 12 -р сарын 13-ны өдөр гаргасан 211 дүгээр тогтоолын дагуу цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын хэрэглээний төлбөрийн тодорхой хэсгийг төр хариуцах шийдвэр гарсны дараа буюу 12 дугаар сарын 15 өдөр эрчим хүчний системийн оргил ачаалал 1309 МВт хүрч өмнөх оны оргил ачааллаас



даруй 156 МВт-аар давж, эрчим хүчний систем суурилагдсан хүчин чадлаараа ажиллаж, ОХУ-аас 252 МВт-ын импортын чадал авах, мөн тодорхой хэрэглэгчдийн хэрэглээг хязгаарлах нөхцөл байдлыг бий болгосон. Эрчим хүчний системд үүссэн хэрэглээний огцом өсөлтийг зохицуулах зорилгоор

оргил ачааллын 18:00-21:00 цагт мэдээлэл бэлтгэж, олон нийтийн сувгаар дамжуулж ажилласны үр дүнд системийн оргил ачаалал 2020 оны 12-р сарын 28-ны байдлаар 1187 МВт хүрч буурсан байна. Энэ нь нийт хэрэглээний огцом өсөлтийг 122 МВт буюу 10 орчим хувиар сааруулсан үр дүнг үзүүлсэн байна.

График 25. Эрчим хүчний системийн 2020 оны 12 дугаар сарын оргил ачааллын график



Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг сайжруулах төсөл хөтөлбөр, хамтын ажиллагааг бэхжүүлэх хүрээнд:

Швейцарын хөгжлийн агентлагаас зарласан байгаль орчин, олон нийтийн салбарыг дэмжих жижиг хэмжээний төслийг санхүүжүүлэх хөтөлбөрт Эрчим хүчний хэмнэлтийн үр дүнгээс бий болох хүлэмжийн хийн бууралтыг хэмжих, тооцох, тайлагнах үндэсний онцлогт тохирсон аргачлал боловсруулах, Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээнд зарцуулах эрчим хүчний хувийн зарцуулалтын тооцох судалгааны төслийн санал бэлтгэж хүргүүлсэн нь дэмжигдэж 324 сая төгрөгийн санхүүжилттэй төсөл хамтран хэрэгжүүлэх гэрээг 2020.09.01-ний өдөр байгуулав. Энэ ажлын үр дүнд олон улсын жишигт нийцсэн эрчим хүчний хэмнэлтийг тооцоолох, тайлагнах тогтолцоо бүрдэх юм.

Эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр хэрэгжүүлж болохуйц төсөл хөтөлбөрийн судалгаа хийж санал боловсруулах хүрээнд УБЦТС ТӨХК-ийн цахилгаан түгээлтийн алдагдлыг бууруулах, аморф трансформаторыг шинэчлэх төслийн судалгааг УБЦТС ТӨХК-тай хамтран гүйцэтгэж

ХКОМ-ын хүрээнд хэрэгжүүлэхээр Монголын талын хуралд танилцуулж Монгол Япон улсын Засгийн газар хоорондын хамтарсан Хорооны хурлаар хэлэлцүүлэхээр тогтов. Мөн Монгол улсын цахилгаан хөдөлгүүр болон давтамж хувиргуурын зах зээлийн судалгаа, эрчим хүчний үр ашгийн судалгааг ДДНХИ-ын дэмжлэгтэйгээр Олон улсын эрчим хүчний хэмнэлтийн хүрээлэнтэй хамтран гүйцэтгэж, эцсийн тайланг боловсруулснаар Цахилгаан хөдөлгүүрийн ЭСКо төсөл хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэв.

Эрчим хүчний хэмнэлтийн төслийг хэрэгжүүлэхэд санхүүгийн хөнгөлөлттэй эх үүсвэрийг бүрдүүлэх, ЭСКо төслүүдийг хэрэгжүүлэх талаар олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах саналыг боловсруулж Дэлхийн банк /World bank/, Японы Хилийн чанад дах байгаль орчны хамтын ажиллагааны төв /OECC/, ЖАЙКА, Даян дэлхийн байгаль орчин стратеги судлалын хүрээлэн /IGES/ зэрэг байгууллагуудад хүргүүлэн ажиллав.

Үүрэг хүлээсэн хэрэглэгчдээс 2020 онд ирүүлсэн нийт 21 аудитын тайланг холбогдох аргачлалын дагуу үнэлж дууссан бөгөөд ДДНХИ-ын дэмжлэгтэйгээр Барилга байгууламжийн ангилалд хамаарах үүрэг хүлээсэн 23 хэрэглэгчид анхан шатны аудит хийлгэх ажлыг зохион байгуулж тайланг хүлээн авсан.


ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛУУД

Эрчим хүчний хэрэглэгчдийг салбарын болон зохицуулалтын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллээр хангах зорилгоор эрчим хүчний зохицуулах хорооны сайтад нийт 204 мэдээлэл бэлтгэж, телевизэд 4 бие даасан нэвтрүүлэг, 4 хэлэлцүүлэг зохион байгуулж, 9 нэвтрүүлэгт зочин оролцуулжээ. Дээрх мэдээллээс 77 мэдээллийг 32 хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 249 /давхардсан тоогоор/ удаагийн түгээлт хийжээ.

- 1** Нийт мэдээллийн 55 хувийг Эрчим хүчний зохицуулах хорооны үйл ажиллагааны мэдээлэл эзэлж байна.
- 2** Эрчим хүчний яам болон тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудтай хамтран гурван сэдвээр сурталчилгааны пи ар ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж 4 хэвлэлийн бага хурал зохион байгуулсан байна.
- 3** “Эрчим хүчний үнэ цэнэ” пэйж хуудсанд 127 мэдээлэл бэлтгэн оруулж, тус цахим хуудсанд хандагчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20 хувиар нэмэгдсэн байна.
- 4** МҮОНТ, Ийгль, ТВ5, HD Монгол телевизтэй хамтран эрчим хүчний салбарын үйл ажиллагаа, үнэ тариф, эрчим хүч хэмнэлтийн талаар мэдээлэл өгөх зорилгоор 4 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулав.
- 5** Эрчим хүчний яам болон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудтай хамтран Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, бүтээн

байгуулалт, цаашдын зорилт, үнэ тарифын зохицуулалтын талаар 3 цуврал нэвтрүүлэг бэлтгэн 7 телевизээр түгээсэн.

- 6** Эрчим хүчний салбарын эдийн засгийн байдал, эрчим хүчний хангамж, аюулгүй ажиллагаа, бодит өртөг, эрчим хүчний үнэ цэнийн талаар олон нийтэд мэдээлэл түгээхдээ 15 телевиз, 6 сонин, 25 сайт, 2 сэтгүүл, 2 радиотой хамтран ажиллав.
- 7** Тайлант хугацаанд Эрчим хүчний яам болон “Улаанбаатар цахилгаан түгээх компани” ТӨХК, “Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, “Дархан, Сэлэнгийн цахилгаан түгээх” ХК, “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК, Хөвсгөл эрчим ХХК зэрэг байгууллагуудын хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн болон холбогдох албан тушаалтнуудтай хамтран ажиллаж, үнэ тариф, зохицуулалтын талаар мэдээлэл түгээж ажилласан байна.
- 8** Эрчим хүчний үнэ тарифыг төрөөс хариуцах Засгийн газрын тогтоол гарсантай холбоотойгоор эрчим хүчний салбарын аюулгүй найдвартай ажиллагааг хангах, эрчим хүч хэмнэлтийг сурталчлах ажлын хүрээнд 2 хэвлэлийн бага хурал зохион байгуулж, нийт 9 төрлийн мэдээлэл бэлтгэн, 26 хэвлэл мэдээллийн байгууллагаар түгээж, эрчим хүчний хэмнэлтийн 8 төрлийн шторкийг цахим орчинд түгээсэн.



ХОРООНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛУУД

Эрчим хүчний зохицуулах хорооны Стратегийн баримт бичиг /2018-2021/-ийн 5 дугаар зорилгын хүрээнд “Эрчим хүчний зохицуулах хорооны хүний нөөцийн сургалт, хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулан Хорооны даргын тушаалаар батлан мөрдөж байна. Тус хөтөлбөрт ажилтан тус бүрээр тэдгээрийн ажлын байрны тодорхойлолтод тулгуурлан цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, сургалтуудыг тодорхойлсон бөгөөд уг хөтөлбөрийн хүрээнд дараах ажилтнуудыг холбогдох сургалтуудад хамруулж байна.

ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

- ХБНГУ-ын Берлин хотын “Beuth” Их сургуулийн магистрын зэрэг олгох эчнээ сургалтад 2020 онд 1 ажилтныг шинээр элсүүлж, өнөөгийн байдлаар нийт 3 ажилтан,
- БНСУ-ын Засгийн газрын тэтгэлгээр AJOU их сургуулийн эрчим хүчний бодлогын чиглэлээр магистрын хөтөлбөрт 2 ажилтныг 2020 оны 9-р сараас сургаж эхэлсэн ба,
- Австрали улсын Засгийн газрын тэтгэлгээр тус улсын Куинсландын Их Сургуулийн магистрын сургалтад 2021 оноос 1 ажилтан суралцах болзол хангаад байна.
- 2020 оны байдлаар БНСУ-ын Сөүлийн их сургуулийн магистрантурт 2 мэргэжилтэн, БНХАУ-ын Бээжин хотын Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн магистрантурт 1 мэргэжилтэн эдгээр сургуулийн 100 хувийн тэтгэлгээр мөн дотоодын их дээд сургуулийн эрчим хүчний менежментийн магистрын хөтөлбөрт 7 мэргэжилтэн суралцаж байна.



БУСАД СУРГАЛТУУД:

- Хүний нөөцийн гадаад хэлний чадавхыг дээшлүүлэх зорилгын хүрээнд Сантис боловсролын төвтэй хамтран нийт 11 мэргэжилтэнг дунд шатны англи хэлний сургалтад хамрууллаа.
- 2020 оныг Байгууллагын соёлын жил болгон зарласантай холбогдуулан нийт ажилтан, албан хаагчдын байгууллагын соёлыг дээшлүүлэхэд оруулах хувь нэмэр, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Байгууллагын соёл, зан төлөв, Эерэг хандлага, Харилцааны соёл, ёс зүй, Цагийн менежмент ба хувийн зохион байгуулалт зэрэг сэдвүүдээр багц сургалтыг нийт ажилтнуудад зохион байгуулсан.

ЗОХИОН БАЙГУУЛСАН УРАЛДААН, ТЭМЦЭЭН:

- “Байгууллага, хамт олны соёл- Зөв хандлага, харилцааны соёл” сэдэвт илтгэх ур чадварын тэмцээн;
- Ажилтан, албан хаагчдад зөв хооллолт, хөдөлгөөний ач холбогдлыг сурталчлах, эрүүл амьдралын хэвшил дадлыг төлөвшүүлэх зорилгын хүрээнд “Зөв хэвшил – Эрүүл амьдрал” болзолт уралдаан;

Бусад

- “Дулааны 4 дүгээр цахилгаан станц” ТӨХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж Хорооны ажилтан, албан хаагчдад үйлчлэх цайны газрыг шинээр байгуулан тохижуулсан.
- “Үнэ цэнэтэй ном” хандивын аяныг зохион байгуулж эрчим хүчний мэргэжлийн чиглэлийн ном сурах бичиг, эрчим хүчний зах зээл, бизнесийн чиглэлийн болон хувь хүний хөгжлийн тухай ном, дэлхийн шилдэг удирдагчдын намтар, зэрэг төрлүүдээр номын санг баяжуулав.

ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН 22 ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ, 117 ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ БАЙГУУЛЛАГАТАЙ ЦАХИМ УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ

Эрчим хүчний зохицуулах хорооноос Аймаг, Нийслэлийн 22 зохицуулах зөвлөлийн дарга, орон тооны гишүүд болон цахилгаан, дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын удирдлагуудтай цахим уулзалт зохион байгууллаа. Энэхүү цахим уулзалтад Улаанбаатар хот, 21 аймгийн Зохицуулах зөвлөлийн гишүүд, цахилгаан дулааны эрчим хүчээр хангах, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч 117 компанийн удирдах албан тушаалтнууд оролцсон байна. Тус уулзалтаар Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүчний төлбөрийг төрөөс хариуцах болсонтой холбогдуулан гарсан түр журмыг танилцуулж, хэрэглэгчдийг 2020-2021 оны халаалтын улиралд стандартын шаардлагад нийцсэн эрчим хүчээр хангах нөхцөлийг бүрдүүлэх, хэрэглэгчдэд хуулиар олгогдсон эрх, үүргийг таниулах, хариуцлагыг дээшлүүлэх, зүй зохистой хэрэглээг сурталчилж ажиллах үүрэг даалгавар өгсөн юм.

А.ТЛЕЙХАН ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН 2020 ОНЫ ШИЛДЭГ МЕНЕЖЕР-ЭЭР ШАЛГАРЛАА



Монгол Улсын гал голомт болсон эрчим хүчний салбар 2020 онд хийсэн ажлаа дүгнэж, шилдэг байгууллага, бүтээн байгуулалт, менежер, ерөнхий инженер, инженер, мастер, ажилтнуудыг тодрууллаа. Эрчим хүчний салбарын 2020 оны **ШИЛДЭГ МЕНЕЖЕР**-ээр Эрчим хүчний зохицуулах хорооны

дарга, Монгол Улсын Аж үйлдвэрийн гавьяат ажилтан А.Тлейхан шалгарчээ.

АНХНЫ СУРГАГЧ БАГШ НАРТ ЗОРИУЛСАН СУРГАЛТ БОЛЛОО



Эрчим хүчний зохицуулах хороо нь Нийслэлийн боловсролын газартай хамтран “Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ” хичээлийг 2017 оноос эхлэн ерөнхий боловсролын бага ангийн сурагчдад заах сургагч багш нарыг бэлтгэх ажлыг амжилттай хэрэгжүүлж байна. Уг хичээлийг заахаар анх бэлтгэгдсэн Нийслэлийн 9 дүүргийн 11 сургуулийн 33 багшийг чадавхжуулах сургалтыг Эрчим хүчний зохицуулах хороо, Нийслэлийн боловсролын газар хамтран 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгууллаа.

Сургалтын үеэр “Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ” хичээлийг заахад гарч байгаа давуу ба сул талуудыг тодорхойлох, хичээлийн хөтөлбөрийг боловсронгуй болгох, цаашид хичээлийг заах арга зүйг боловсруулан гаргах асуудлуудыг хэлэлцсэн. Мөн “Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ” сэдвийн агуулгыг хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөрийг ерөнхий боловсролын бага ангийн сургалтын агуулгад тусгуулахаар бэлтгэх, сургалтын хэрэглэгдэхүүн, гарын авлага, зөвлөмжийг боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллахаар боллоо.

ДУЛААНЫ ТООЛУУРЫГ СУУРИЛУУЛАХ, АШИГЛАХТАЙ ХОЛБООТОЙ МЭДЛЭГ, МЭДЭЭЛЭЛ ОЛГОХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Эрчим хүчний зохицуулах хорооноос Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүдийн орон тооны гишүүд болон 21 аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дэд бүтэц хариуцсан мэргэжилтнүүдэд дулааны тоолуурыг суурилуулах, ашиглахтай холбоотой мэдлэг, мэдээлэл олгох сургалт зохин байгуулав. Төрийн болон орон нутгийн



өмчит хуулийн этгээд, бусад төсөвт байгууллагуудыг тоолууржуулах тухай Засгийн газрын тогтоол гарсан үед тоолуур суурилуулах, дулааны тоолуур, хэмжих хэрэгсэлд тавих шаардлага, стандарт, суурилуулах үед анхаарах асуудлууд, ашиглалт, засвар үйлчилгээ зэрэг сэдвийн хүрээнд энэхүү сургалтыг зохион байгуулснаараа онцлогтой юм. Сургалтыг Эрчим хүчний зохицуулах хороо, ШУТИС-ийн Эрчим хүчний сургуулийн багш нар, Стандарт, хэмжил зүйн газрын Хэмжил зүйн хүрээлэн, Төрийн худалдан авах ажиллагааны газар, “УБДС” ТӨХК-ийн Хэмжүүр хяналт, баталгаажуулалтын алба, дулааны тоолуур борлуулагч компаниудтай хамтран зохион байгуулсан юм.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХАМТ ОЛОН НЭГ ӨДРИЙН ЦАЛИНГАА ХАНДИВЛАЛАА

Дэлхий дахинд шинэ Коронавирус COVID-19 өвчний халдварын тархалт буурахгүй өргөн хүрээнд дэгдэж, Монгол Улсад Засгийн газар, Онцгой байдлын комиссоос цаг алдалгүй арга хэмжээ авч ажиллаж байгаа. Шинэ коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх эрсдэлд нөхцөл байдлыг даван туулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Эрчим хүчний зохицуулах хорооны ажилтан, албан хаагчид нэг өдрийн цалингаа Улсын онцгой комисст хандивласан байна.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС ХЭРЭГЛЭГЧДЭД ХАНДАН ЗӨВЛӨМЖ ГАРГАЛАА

Аймгийн төв, арван мянгаас дээш хүн амтай сум суурин газрын агаарын бохирдлыг бууруулах, айл өрхөд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журамд өөрчлөлт оруулан 50 хувиар хөнгөлж байсныг 100 хувиар тооцож хөнгөлөлт үзүүлэх шийдвэр Засгийн газраас гарсны дагуу Эрчим хүчний зохицуулах хорооноос холбогдох журмуудыг батлав. Энэхүү журам хэрэгжиж эхэлснээр Улаанбаатар хотод 117

мянган айл өрх, 21 аймгийн төв, Сэлэнгэ аймгийн Мандал, Өвөрхангай аймгийн Хархорин, Дорноговь аймгийн Замын-Үүд зэрэг 10 мянгаас дээш хүн амтай сум, суурин газруудад 72 мянган айл өрх, нийт 189 мянган гэр хорооллын айл өрх 100 хувийн цахилгааны тарифын хөнгөлөлтөд хамрагдах боломжтой болсон юм. Гэр хорооллын хэрэглэгчдэд үзүүлэх тарифын хөнгөлөлт нь агаарын бохирдлыг бууруулах, мөн гэр хорооллын айл өрхийн хэрэглэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх гол зорилготой. Гэр хорооллын айл өрхийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний тарифт хөнгөлөлт үзүүлснээр 220 В-ын хүчдэлийн түвшинтэй 1 өрх сард дунджаар 80000 төгрөгийн, 380 В-ын хүчдэлийн түвшинтэй 1 өрх сард дунджаар 160000 гаруй төгрөгийн хөнгөлөлт авах боломж бүрдэж байгаа юм. Энэ шийдвэр 11-р сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Эрчим хүчний зохицуулах хорооноос хэрэглэгчдэд хандан зөвлөмж гаргажээ.



ДУЛААН ТҮГЭЭХ, ДУЛААНААР ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАНГАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТ БОЛЛОО

Эрчим хүчний зохицуулах хорооноос хэрэглэгчдийг 2020-2021 оны халаалтын улиралд ая тухтай өвөлжих нөхцөлийг бүрдүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор 3 дахь жилдээ “Дулаан орчин-хэрэглэгчийн ая тух-2020” сэдэвт аяныг зохион байгуулав. Аяны хүрээнд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн дулаан түгээх, хангах үйл ажиллагаа, техникийн бүрэн бүтэн байдал, хэрэглэгчийн санал, хүсэлтийн барагдуулалт, диспетчерийн үйл ажиллагаа, баримт бичгийн бүрдэл зэргийг шалгаж, аваар, саатлаас урьдчилан сэргийлэх, гарсан гэмтэл саатлыг түргэн шуурхай засварлах ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан төлөвлөгөөний дагуу дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч хувийн хэвшлийн 66 компани, орон нутгийн өмчит нэг компанийн нийт 67 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 190 гаруй ажилтан, албан хаагчдыг хамруулсан чадваржуулах сургалтыг амжилттай зохион байгуулж, Тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд 100 хувийн ирцтэй оролцжээ.

ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



ДЭЛХИЙН БАНК

Дэлхийн банкны техникийн туслалцаатайгаар хэрэгжүүлэх төсөл, ажлуудыг зохион байгуулах, явцын талаар мэдээлэл солилцох, дараагийн үе шатны ажлын эзлэхүүнийг тохирч ажлын даалгаврыг боловсруулах зорилгоор ЭХЗХ болон Дэлхийн банкны удирдлагын түвшинд уулзалт хэлэлцээрийг тогтмол хийх, хамтын ажиллагааны эргэх холбоог хангах чиглэлээр байнгын үйл ажиллагааг зохион байгуулж ирсэн ба эдгээр бүх үйл ажиллагаанд зөвлөхүүд болон холбогдох талуудыг мэдээллээр хангаж ажиллав.



ДАЯН ДЭЛХИЙН НОГООН ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

Даян дэлхийн ногоон хөгжлийн хүрээлэнтэй 2017 онд тогтоосон түншлэлийн харилцааг бэхжүүлэх чиглэлээр ажилласан. Хороо болон ДДНХХ-ийн удирдлагын түвшинд онлайн уулзалт зохион байгуулж, шинээр томилогдоод байгаа Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын дарга Аннака Петерсонтой уулзах, ЭХЗХ болон хамтын ажиллагааны хүрээнд хүрсэн үр дүн, цаашид явуулах үйл ажиллагааны талаар хэлэлцсэн болно.



ГЕРМАНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ НИЙГЭМЛЭГ

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Угсармал орон сууцны барилгын дулаан техникийн шинэчлэл” төслийн хүрээнд “Улаанбаатар хотын эрчим хүч хэмнэлтийн хөтөлбөр” боловсруулах ажлыг Хорооны зүгээс дэмжин, хэрэгжилтийг хариуцан хамтран ажиллаж байна.



АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК (АХБ)

АХБ-тай хамтран эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор тус байгууллагатай холбоо тогтоох ажлыг зохион байгуулсан бөгөөд албан бичиг, цахим шуудангаар харилцах, хоёр талын санаачилгаар уулзалт зохион байгуулах ажлууд хамтын ажиллагааны хүрээнд тогтмол хийгдэж байна. ЭХЗХ-оос эрчим хүчний салбар дахь хамтын ажиллагааг улам бэхжүүлэх, эрчим хүчний салбарыг зах зээлийн зарчмаар хөгжүүлэх, хэмнэлт, үр ашгийг сайжруулах хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, ЭСКО механизмыг дэмжих, эдгээрийн хүрээнд хүний нөөцийг чадвахжуулах чиглэлээр хамтран ажиллах хүсэлтийг Хорооноос гаргасан бөгөөд АХБ-наас өргөн хүрээнд хамтран ажиллахаа илэрхийлээд байна.

Монгол Улсын Засгийн газар, Олон улсын валютын сантай хамтран ажиллах бодлогын хэрэгжилтийн хүрээнд Улаанбаатарын агаарын чанарыг сайжруулах төслийн 2 дугаар үе шат “Гэр хорооллын цахилгаан халаалтын үнэ тарифын татаас”-ын талаар Азийн хөгжлийн банк, Сангийн яам, ЭХЯ-тай хамтран бодлогын хэрэгжилтийн судалгаа хийлгэх талаар хамтарч ажилласан. Олон улсын зөвлөхүүд, АХБ, Сангийн яам хамтран 2 удаа цахим уулзалт хийсэн.



АНУ-ЫН ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагтай (АНУОУХА) хамтран ажиллах тухай ЭХЗХ-ны хүсэлтийн дагуу хамтын ажиллагааг эхлүүлэх талаар тодорхой ажлуудыг хийгээд байна. 2020 оны 1 дүгээр сард АНУОУХА-ийн Манила дахь оффисын Хүрээлэн буй орчин хариуцсан дарга Жон Эдгартай хамтын ажиллагааны боломжит чиглэлүүдийн талаар санал солилцох уулзалтыг Хороон дээр зохион байгуулсан. Тус агентлагаас эх үүсвэрүүдийн төлөвлөлт, Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үр ашгийг сайжруулах “Зохицуулалтын чадавх, төлөвлөлтийг сайжруулах”, “Зах зээлийн өрсөлдөөн, компаниудын гүйцэтгэлийн үзүүлэлт”, “Орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх” гэсэн ерөнхий 3 чиглэлээр хэрэгжүүлэх төслийн төлөвлөгөө, өөрчлөлтийн онолын саналыг боловсруулахад хамтран ажилласан. Үүний үр дүнд тус агентлагийн санхүүжилттэй “Монгол Улсын эрчим хүчний засаглалын үйл ажиллагаа” сэдэвт төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.



ЕВРОПЫН ХОЛБООНООС МОНГОЛ УЛСАД СУУГАА СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР

Европын Холбооноос Монгол улсад суух Суурин төлөөлөгчийн газартай холбоо тогтоон хамтран ажиллах асуудлаар уулзалт зохион байгуулсан. Европын холбооноос Монгол улсад суугаа Элчин сайдтай хийсэн уулзалтын үеэр ярилцсаны дагуу дамжуулах, түгээх шугам сүлжээг өргөтгөхөд хөрөнгө оруулалтыг татах бодлого, зохицуулалтын орчинг сайжруулах тухайлбал холболтын болон тарифын урамшуулалт зохицуулалтыг боловсруулах, ухаалаг тоолуурын хэрэглээг нэмэгдүүлэн улмаар эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, Хорооны хүний нөөцийг мэргэшүүлэх, чадавхжуулах зэрэг тодорхой чиглэлээр дэмжлэг авч, хамтран ажиллахаар төлөвлөж байна.



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАГЧДЫН БҮСИЙН НИЙГЭМЛЭГ (ЭРРА)

ЭХЗХ нь 2004 онд Эрчим хүчний зохицуулагчдын бүсийн нийгэмлэгт гишүүнээр элссэн. Гишүүнчлэлийн хүрээнд жил бүр цахилгааны тарифын мэдээлэл, удирдлагын бүтцийн талаарх шинэчлэгдсэн мэдээллийг хүргүүлэх, тодорхой асуудлаар гишүүн орнуудын зохицуулах байгууллагаас мэдээлэл авах тал дээр хамтран ажиллаж байна. 2020 онд тус байгууллагын мэдээллийн санд байдаг сургалт, судалгааны материалыг Хорооны ажиллагсдад хүртээмжтэй болгох, мэдлэг чадвар, мэргэжлийн англи хэлээ дээшлүүлэхэд ашигладаг болгох чиглэлээр тодорхой ажлыг төлөвлөн ажилласан. Оны сүүлийн хагас жилээс эхлэн нийгэмлэгээс зохион байгуулсан онлайн арга хэмжээний талаарх мэдээллийг Хорооны Абле системийн “Олон нийтийн” цэс дээр байршуулах, албан хаагчдад сургалтад хамрагдах боломжийг нээлттэй болгох, хүсэлтийн дагуу онлайн арга хэмжээнд бүртгүүлэх, хамруулах ажлыг зохион байгуулсан. Онлайн хэлбэрээр зохион байгуулагдсан ЭРРА-ийн 2020 оны удирдлагын чуулга уулзалт, удирдах зөвлөлийг шинээр сонгох үйл ажиллагаанд Хорооны удирдлагын багаас 2 хүн оролцлоо. Эрчим хүчний зохицуулагчдын бүсийн нийгэмлэгт ЭХЗХ-ны талаарх мэдээллийг шинэчлэн хүргүүлэх, тус байгууллагын 2015 оноос зохион байгуулсан арга хэмжээнүүдийн материалыг татан авч бүх ажиллагсдыг сургалтын материал, сургалтын хүрээнд авч үзсэн олон улсын судалгааны ажилтай танилцах, судлах боломжоор хангасан.



БНСУ-ЫН ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА

БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-ийн “Эрчим хүчний шинжлэх ухаан, бодлого” магистрын тэтгэлэгт хөтөлбөрийн шалгуурт Хорооны хоёр ажилтан тэнцэж, 2020 оноос БНСУ-ын АЖОУ-гийн Их сургуульд суралцаж байна. Мөн тус байгууллагаас зохион байгуулдаг “Групп сургалт”-ын хөтөлбөрт хамрагдах санал боловсруулан холбогдох байгууллагууд руу хүргүүлээд байна.

2021 ОНЫ ЗОРИЛТУУД:

Эрчим хүчний зохицуулах хороо нь үндсэн чиг үүрэг, зорилгын хүрээнд 2021 онд дараах зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллана. Үүнд:

НЭГ.

Эрчим хүчний ухаалаг сүлжээ, тогтолцоог хөгжүүлэх, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтийн хяналтыг сайжруулж тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах;

ХОЁР.

Эрчим хүчний үнэ тарифын тогтолцоог сайжруулах, зах зээлийн оновчтой загварыг нэвтрүүлэх боломжийг тодорхойлох;

ГУРАВ.

Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр (2018-2022 он)-ийн хэрэгжилтийг хангах, үүрэг хүлээсэн хэрэглэгчдэд эрчим хүчний хэмнэлт гаргах, бодит үр дүнд хүрэх ажлыг зохион байгуулах;

ДӨРӨВ.

Хорооны үйл ажиллагааны цахим мэдээллийн системийг өргөжүүлэн хөгжүүлэх, Эрчим хүчний салбарт зохицуулалтын байгууллага үүсч хөгжсөн түүхэн замналыг баримтжуулах;



Эрчим хүчний үнэ цэнэ



-  Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 14201, Ж.Самбуугийн гудамж 30
-  Утас: 976-11-320126
-  Факс: 976-11-319335
-  И-мэйл: info@erc.gov.mn
-  Вэб сайт: erc.gov.mn
-  [www.fb.com/Эрчим хүчний үнэ цэнэ](https://www.facebook.com/Эрчим-хүчний-үнэ-цэнэ)
-  [twitter.com/Эрчим хүчний үнэ цэнэ](https://twitter.com/Эрчим-хүчний-үнэ-цэнэ)